

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР
ДҮН”-д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: /ДУА-2025/40-ШТА-ГА/

Дундговь аймаг дахь Төрийн аудитын
газрын Дарга, тэргүүлэх аудитор
Р.Мөнхтогтох Утас: 70592439

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор О.Баярсайхан

Ахлах аудитор Д.Ихбаяр

Аудитор Л.Уранбилэг

Аудитор Г.Үүрийнтуяа

Утас: 7059-2208

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгс	4
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-8
	Дүрслэлийн товчъёг	9-10
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	<u>БҮЛЭГ 1. Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн эрүүл мэндийн салбарын зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг батлаагүй байна.</u>	11-18
Аудитын менежер Т.Батсайхан Ахлах аудитор О.Баярсайхан Д.Ихбаяр Аудитор Л.Уранбилэг Г.Үүрийнтуяа	<u>Бүлэг 2. Орон нутагт нэн шаардлагатай эмч, сувилагч, тусгай мэргэжилтнийг мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлсэн байна.</u>	19-28
	<u>Бүлэг 3. Тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтэд тавьсан хязгаарлалт, нэхэмжлэлийн хасагдал өндөр байгаа нь байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэл үүсгэж байна.</u>	28-40
	Дүгнэлт	41
	Зөвлөмж	42-43
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70593208 дугаарын факсаар харилцана уу.	Шалгагдагч байгууллагын санал тайлбар	44
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 213 тоот 2025 оны 12 дугаар сар	Хавсралт	45-58



Тайлан баталгаажуулах тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 19/43

Монгол

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан (ДУА-2025/40-ШТА-ГА)-г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Эрүүл мэндийн газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар заасан хугацаанд Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун), аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Лхагвабаатар), Эрүүл мэндийн газрын дарга (Б.Алтантөгс), Нэгдсэн эмнэлгийн дарга (А.Амартүвшин), сумдын Засаг дарга нарт зөвлөсүгэй.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2026 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын хоёрдугаар нэгжийн ахлах аудитор (О.Баярсайхан)-д үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ

4825010135

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХШҮХ	Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс
ХШҮ	Хяналт, шинжилгээ үнэлгээ
УАУНЭ	Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс
НЭ	Нэгдсэн эмнэлэг
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн салбар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ӨМӨЗО	Өвөр Монголын өөртөө засах орон
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЭМТҮ	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
АХ	Арга хэмжээ
ОН	Орон нутгийн
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
ДУА	Дундговь аймаг
ШТА	Шууд тайлагнах ажил
ГА	Гүйцэтгэлийн аудит

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл,
бүрэн эрх:

Аудитын зорилт:

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолд тусгасны дагуу “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгжилт, үр дүн”-д Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудит хийлээ.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн салбарын бодлого, зорилтыг оновчтой төлөвлөж, үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;
- ✓ Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа үр дүнтэй эсэх;
- ✓ Анхан болон лавлагаа шатлалын эмнэлгүүд төсвийн орлогыг аргачлал, зааврын дагуу бодитой төлөвлөн бүрдүүлж, үйл ажиллагаагаа үр ашигтай явуулсан эсэх;

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль (2015 он);
- ✓ Эрүүл мэндийн тухай хууль (2011 он);
- ✓ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (2015 он);
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль (2015 он);
- ✓ "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол);
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай (УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол);
- ✓ "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин" (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол);
- ✓ Эрүүл мэндийн салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030 он)
- ✓ Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2020-2023 оны тогтоолууд;
- ✓ Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022-

Аудитын хамарсан
хүрээ:

Аудитын арга зүй:

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитын дүн

**ҮНДСЭН
МЭДЭЭЛЭЛ**

- 2025 оны тушаалууд;
- ✓ Дундговь аймгийн стратеги төлөвлөгөө (2021-2025 он)
- ✓ Дундговь аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020-2025 он)
- ✓ Дундговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр (2021-2024 он)
- ✓ Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

Аудитад эрүүл мэндийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг эмнэлгүүдийн бодлогын баримт бичиг, зорилго, зорилтын хэрэгжилт, хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны үр дүн, төсвийн төлөвлөлт, орлогын бүрдүүлэлт, бусад нотлох баримт, материалыг хамруулж хийлээ.

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Т.Батсайхан үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, ахлах аудитор О.Баярсайхан, Д.Ихбаяр, аудитор Л.Уранбилэг, Г.Үүрийнтуяа нар 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

Аудитаар нийт 28.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчил арилгуулахаар 2 хугацаатай албан шаардлага, аймгийн Засаг дарга болон бусад албан тушаалтанд 13 заалт бүхий зөвлөмж хүргүүлээ.

УИХ-аас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр болжээ.

Дундговь аймагт Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Сум дундын эмнэлэг 2, сумдын Эрүүл мэндийн төв 13, Өрхийн эрүүл мэндийн төв 2, Зоонзлын өвчин судлалын төв, Уламжлалт анагаах ухааны төв, хувийн ортой эмнэлэг 1 эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж, улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас

санхүүжиж байна. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хувьд 2025 онд 664 орон тоо батлагдсанаас 79 орон тоо дутагдалтай байна. Үүнээс Дэлгэрхангай, Цагаандэлгэр, Сайхан-Овоо, Дэрэн сумд дийлэнх хувийг эзэлж байна.

2023 онд аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-өөс эрүүл мэндийн салбарт 28.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээс 14 оюутанд 14.8 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг, 4 албан хаагчид 4.0 сая төгрөгийн мэргэшил дээшлүүлэх сургалтын төлбөрийн дэмжлэг, 2 албан хаагчид нийгмийн баталгааг хангах зорилгоор 10.0 сая төгрөгийн байрны төлбөрийн дэмжлэгийг тус тус олгосон байна. Харин 2024 онд нийт 17 албан хаагч, 7 оюутанд 121.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Үүнээс 75 хувь буюу 90.0 сая төгрөгийг 11 албан хаагчид нийгмийн баталгааг дэмжих зорилгоор зарцуулжээ. Мөн 3 албан хаагчид гадаад сургалтад хамруулахаар 7.0 сая төгрөг, 1 албан хаагчид 6.0 сая төгрөгийн эмчилгээний дэмжлэг, 9 оюутан, албан хаагчид сургалтын төлбөрийн дэмжлэгийг олгосон байна.

Дундговь аймгийн эрүүл мэндийн салбар 2024 оны төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,676.1 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 20,946.7 сая төгрөг, өөрийн орлогын эх үүсвэрээс 1,110.5 сая төгрөг буюу нийт 24,733.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 24,696.9 сая төгрөгийг зарцуулж, 2,105.7 сая төгрөгийн өр, 1,824.6 сая төгрөгийн авлагатай байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 2024 онд нийт 170,920 тусламж үйлчилгээ үзүүлж 24,774.1 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс 3,591 тусламж үйлчилгээний 934.3 сая төгрөгийн санхүүжилтийг цахим хяналт, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн эмч, байцаагчийн хяналтаар хасаж, 167,809 тусламж үйлчилгээний 23,961.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Хяналтаар хасагдсан 3,591 тусламж үйлчилгээ нь нийт тусламж үйлчилгээний 2.1 хувийг, хасагдсан санхүүжилтийн дүн 934.3 сая төгрөг нь нийт нэхэмжилсэн санхүүжилтийн 3.8 хувийг тус тус эзэлж байна.

Харин 2025 оны эхний хагас жилийн тайлангаар улсын төсвөөс 999.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 12,553.8 сая төгрөг, өөрийн орлогын эх үүсвэрээс 424.1 сая төгрөг буюу нийт 12,553.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 12,090.1 сая төгрөгийг зарцуулж, 2,614.9 сая төгрөгийн өр, 948.5 сая төгрөгийн авлагатай байна. Нийт өр төлбөр өмнөх оноос 509.2 сая төгрөгөөр өсөж, авлага 876.1 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд 183,334 үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 20.5 %, амбулаторийн үзлэг 62.4 %, идэвхтэй хяналт 10.5 %, гэрийн идэвхтэй хяналтын үзлэг 5.6 %, гэрийн дуудлагын үзлэг 0.9 %-ийг эзэлж байна. Мөн эмнэлэгт шинээр 11,212 эмчлүүлэгч хэвтэж, 11,162 эмчлэгдэж эмнэлгээс гарсан бөгөөд нийт 81,616 ор хоног ашиглажээ. Өмнөх онтой харьцуулахад шинээр хэвтэж эмчлүүлэгчийн тоо 861, эмчлэгдэж



эмнэлгээс гарсан эмчлүүлэгчийн тоо 907-оор өссөн үзүүлэлттэй байна. 2024 онд эрт илрүүлэг үзлэгт нийт хүн амын 47.2 хувь буюу 22,273 хүн хамрагдсан бөгөөд өмнөх оноос 4.5 хувь буюу 2,105 хүнээр нэмэгдсэн байна.

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Дундговь аймгийн эрүүл мэндийн салбарын 2021-2024 он хүртэлх дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт	11
Хүснэгт 2	“Эрүүл Дундговь” дэд хөтөлбөрийн 2025 онд санхүүжсэн эх үүсвэрээр харуулбал /сая.төг/	13
Хүснэгт 3	Эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө аймгийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал:	13
Хүснэгт 4	АЗДТГ-ын ХШҮХ-ийн 2023, 2024 оны үнэлгээг шалгуур үзүүлэлт бүрээр харуулбал:	16-17
Хүснэгт 5	Эрүүл мэндийн яамнаас хийсэн үнэлгээний дүн	17
Хүснэгт 6	Бодлогын баримт бичигт эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн талаар хэрхэн тусгасан байдал	19
Хүснэгт 7	Эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал /Сая.төг/	19-20
Хүснэгт 8	Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний нэмэгдсэн, хасагдсан судалгаа	23
Хүснэгт 9	Төсөвт учирсан хохирол, түүнийг барагдуулсан байдал /Сая.төг/	28
Хүснэгт 10	Лавлагаа шатны эмнэлгийн үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл	31
Хүснэгт 11	Лавлагаа шатлалын эмнэлгийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний өсөлт	32
Хүснэгт 12	Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээ үзүүлж санхүүжилт авсан байдал	33
Хүснэгт 13	ЭМБ-уудын үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд суурилан үнэлгээ хийж нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 20 хувийн олголтыг тооцсон мэдээлэл	37
Хүснэгт 14	Нэгдсэн эмнэлгийн өр, төлбөрийн мэдээлэл	39

Графикийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн www.opendata.1313.mn сайтад бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудын амбулаториор үзүүлсэн иргэнээс авсан судалгааг харуулав.	14
График 2	Эрүүл мэндийн салбаруудын хэвтэн эмчлүүлсэн иргэнээс авсан судалгааг графикаар харуулав.	15
График 3	АЗДТГ болон Эрүүл мэндийн яамны 2022-2024 оны ХШҮ-ний дүнг харуулав.	17
График 4	Эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтэд 2022-2024 онд хийсэн ХШҮ-г графикаар харуулав.	18
График 5	Эмнэлгүүдээс эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ авч чаддаггүй гэж хариулсан байдлыг харуулбал:	18
График 6	Эрүүл мэндийн яамнаас 2021-2024 онуудад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн	21
График 7	Эрүүл мэндийн салбарт 2025 оны 10 дугаар сарын байдлаар ажиллаж буй албан хаагчдын тоо	22
График 8	Салбарын 2021-2025 оны хүний нөөцийн байдал	22
График 9	2021-2025 онуудад ажлаас чөлөөлөгдсөн болон ажилд орсон эмч, сувилагчийн тоо	23
График 10	2021-2025 онуудад төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгаа	24
График 11	Гадаад сургалтын талаар мэдээлэл (2023-2025 он)	24
График 12	"Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-өөс 2021-2025 онд олгосон дэмжлэг	25

График 13	"Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-өөс олгосон дэмжлэгийг төрлөөр харуулав.	26
График 14	ЭМБ-уудын орлогын төсвийн төсөвлөлт /Сая.төг/	29
График 15	Анхан шатны ЭМБ-уудын орлогын гүйцэтгэл	30
График 16	Лавлагаа шатны ЭМБ-уудын орлогын гүйцэтгэл	30
График 17	Нэгдсэн эмнэлгийн өөрийн орлогын төрөл	32
График 18	Санхүүжилтийн хасагдлын мэдээ	33
График 19	Санхүүжилтийн хасагдлын төрөл	33
График 20	Санал асуулгын дүнгээс	35
График 21	Нэг иргэнээр тооцсон санхүүжилт, гүйцэтгэл	37
График 22	ЭМБ-уудын өр, төлбөрийн судалгаа	38
График 23	ЭМБ-ын өр, авлагын эзлэх хувь	38
График 24	Өр, төлбөрийн агуулга /Хувиар/	38
График 25	ЭМБ-ын өр, авлагын эзлэх хувь	39
График 26	Нэгдсэн эмнэлгийн өр, авлага харьцуулалт	39
График 27	Нэгдсэн эмнэлгийн зардлын бүтэц	39



БҮЛЭГ 1. ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН 2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛААГҮЙ БАЙНА.

1.1 Эрүүл мэндийн салбарын бодлого зорилтыг хэрэгжүүлэх талаар баримталж буй бодлого төлөвлөлт, байгууллага хоорондын үйл ажиллагааны үялдаа холбоо хангалтгүй байна.



Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 15-ны А/609 тушаалаар эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөөг баталсан байна. Уг стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг аймаг, нийслэлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгож, аймгийн Эрүүл мэндийн газар аймгийн эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг гаргасан байна.

Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталжээ. Харин аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн эрүүл мэндийн салбарын зорилтыг хэрэгжүүлэх 2025-2028 оны стратеги төлөвлөгөө батлаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах” журмын 2.1¹, 2.3² дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/70 дугаар тушаалаар эрүүл мэндийн салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулж, ажил хийгдээгүй байна.

Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд нийт 8 стратеги зорилт дэвшүүлж, 115 арга, хэмжээний биелэлтийг хангаж хэрэгжилтийн дундаж 93.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна. Үнэлгээг ЭМГ-ын удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсээс хийсэн байна.

Хүснэгт №-1 Дундговь аймгийн эрүүл мэндийн салбарын 2021-2024 он хүртэлх дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт

Бодлогын баримт бичгийн нэр	Стратегийн зорилт	ЭМТҮ-тэй холбоотой арга хэмжээ	Биелэлтийн хувь	Хүрэх түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих боломжтой эсэх
Эрүүл мэндийн салбарын стратеги төлөвлөгөө 2021-2024	8	25	93	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус	Шалгуур тодорхойгүй

**Эх сурвалж: Эрүүл мэндийн газар*

¹ Стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд арга хэмжээний төлөвлөгөө батлагдсанаас хойш хоёр сарын дотор салбарын, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн, байгууллагын стратеги төлөвлөгөөг тус тус дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулна.

² Яамны харьяа агентлаг нь байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулан салбарын сайдаар, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг аймаг, нийслэлийн Засаг даргаар тус тус батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулна.

Дээрх хүснэгтээс харахад эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг тайлагнасан хэдий ч шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэр, хүрэх түвшин тодорхой бус байна.

Аудитаар аймгийн нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, Сайнцагаан, Эрдэнэдалай, Баянжаргалан, Хулд сумдын Эрүүл мэндийн төвүүдийг аудитад түүвэрлэн хамрууллаа. Үүнээс: Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, Эрдэнэдалай сумын эрүүл мэндийн төв нь 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг баталсан хэдий ч зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь түвшин, зорилтод түвшнийг өөрийн сумын нийгмийн үзүүлэлт, онцлогтой уялдуулан боловсруулаагүй, тооцоо судалгаанд үндэслээгүй, урьд жилүүдийн стратеги төлөвлөгөөтэй зорилго, зорилт хэрэгжүүлэх арга хэмжээг адил баталсан байна.

Харин Нэгдсэн эмнэлэг, Сайнцагаан, Баянжаргалан, Хулд сумд стратеги төлөвлөгөө батлаагүй байна.

Иймд Эрүүл мэндийн салбарын хэмжээнд 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг батлуулж, тооцоо судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоон, жил бүрийн хүрэх түвшин, хийгдэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж ажиллах нь зүйтэй байна.

Улсын хэмжээнд хэрэгжиж байгаа хөтөлбөрүүд болон аймгийн ИТХ-аас “Эрүүл Дундговь” дэд хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн эрүүл мэндийн салбар улсын хэмжээний 5 хөтөлбөр, арга хэмжээ, аймгийн хэмжээний 1 хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөн /2021-2026/
- “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” /2022-2025/
- “Эрүүл шүд” арга хэмжээ /2024-2027/
- “Иргэний эрүүл мэндийн боловсрол дээшлүүлэх” арга хэмжээ /2024-2027/
- “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээ /2024-2027/
- “Эрүүл Дундговь” хөтөлбөр /2025-2028/

Засгийн газрын зарим чиг үүргийг эрүүл мэндийн салбарт орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд дээрх улсын хэмжээний 5 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулан шат дараатайгаар Эрүүл мэндийн газрын даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж байна.

Мөн аймгийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн захирамжаар “Эрүүл иргэнтэй Дундговь” дэд хөтөлбөрийг 2018-2021 онд Эрүүл мэндийн газар, харьяа эрүүл мэндийн байгууллагууд болон бусад төрийн болон төрийн бус байгууллагууд хэрэгжүүлж дууссан байна. Харин 2025-2028 онд “Эрүүл Дундговь” нэртэйгээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан байна.

Энэ хөтөлбөр нь 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 161.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 2,258.6 сая төгрөг, төсөл хөтөлбөрөөс 281.4 сая төгрөг нийт 2,626.1 сая төгрөгөөр санхүүжих дараах 3 зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- ✓ Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөлийг эрт илрүүлэх, эмчлэн эрүүлжүүлнэ.
- ✓ Эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинэ технологийг нэвтрүүлнэ.
- ✓ Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлж, өвчлөл, нас баралтын шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2025 оны 10 сарын байдлаар 3 зорилтын хүрээнд 15 хэрэгжүүлэх үйл ажиллагааны 47 заалт хэрэгжихээс 2 заалт хэрэгжээгүй ба нийт хэрэгжилтийн хувь 77.9 хувьтай үнэлэгдсэн байна.

Хүснэгт №-2: “Эрүүл Дундговь” дэд хөтөлбөрийн 2025 онд санхүүжсэн эх үүсвэрээр харуулбал /сая.төг/

№	АХ-ний тоо	Улсын төсвөөс	АХ-ний тоо	ОН-ийн төсвөөс	АХ-ний тоо	Хандив, тусламж	АХ-ний тоо	Төсөл, хөтөлбөр
Төлөвлөсөн	8	161.9	33	2,182.8	-	-	2	281.4
Санхүүжсэн дүн	14	1,649.7	21	627.3	2	273.1	2	31.5

*Эх сурвалж: Эрүүл мэндийн газар

Хүснэгтээс харахад 2025 оны 10 сарын байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14 арга хэмжээний 1,649.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 21 арга хэмжээний 627.3 мянган төгрөг, хандив тусламжийн 2 арга хэмжээний 273.1 мянган төгрөг, төсөл хөтөлбөрийн 2 арга хэмжээний 31.5 мянган төгрөг, нийт 39 арга хэмжээний 2,581.6 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлсэн байна.



Аймгийн 2021-2025 оны жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой 2 зорилт, 6 арга хэмжээ, Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн байгууллагуудтай холбоотой 5 зорилт, 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсанаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой 1 зорилт, 7 арга хэмжээ, аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус баталсан байна.

Харин аймгийн эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд 8 зорилт, 115 арга хэмжээ тусгагдсанаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой 1 зорилт, 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт №-3: Эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө аймгийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал

№	Бодлогын баримт бичгийн нэр	Аймаг, нийслэл хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл			Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр			Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө		
		Нийт	Тусгасан	Тусгаагүй	Нийт	Тусгасан	Тусгаагүй	Нийт	Тусгасан	Тусгаагүй
1	Эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний ЭМТҮ-тэй холбоотой заалт	6	4	2	7	6	1	5	4	1

/Дэлгэрэнгүй заалтуудыг хавсралт 1 дүгээр хүснэгтээс харна уу/

Хүснэгтээс харахад аймгийн 2021-2025 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой 6 заалт тусгагдсанаас 4 заалт эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгаж, 2 заалт тусгаагүй, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт 7 заалт тусгагдсанаас 6 заалт тусгаж, 1 заалт тусгаагүй, аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан 5 заалтаас 4 тусгаж, 1 заалт тусгаагүй байна.

Мөн арга хэмжээний жил бүрийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийг тусгасан боловч эх үүсвэр тодорхойгүй, эрүүл мэндийн үндсэн гол үзүүлэлтүүд болох хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт, зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулах, нэгдсэн эмнэлэг болон сумдын эмнэлгүүдийн эхчүүдийн амрах байрны орчин нөхцөлийг сайжруулах зэрэг заалтууд орхигдсон байна.

Энэ нь Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулахтай холбоотой ажлыг хариуцсан байгууллага хоорондын уялдаа холбоо муу, урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслээгүй, жил бүр хийгдэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргаагүй, хэрэгжилтийн үр дүнг тооцоогүйтэй холбоотой байна.

Эрүүл мэндийн салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлахдаа аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт арга, хэмжээтэй уялдуулан төлөвлөж, бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээг бүрэн тусгаж байх шаардлагатай байна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5.8³-д эрүүл мэндийн байгууллага бүр хэрэглэгчийн үнэлгээг тогтмол авч байх, салбарын нэгдсэн үнэлгээг Эрүүл мэндийн хөгжлийн төв хариуцан зохион байгуулахаар зохицуулсан байна.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авахдаа тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг харгалзан асуумж боловсруулан авч, үнэлгээний дүн, тайланг бодлого, үйл ажиллагаандаа тусгаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад ашиглахаар заасан байна.

Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсээс харьяа эрүүл мэндийн байгууллагуудад жил бүр төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, хэрэглэгчийн үнэлгээ болон салбарын нэгдсэн үнэлгээг авах талаар зөвлөмж чиглэл өгч ажилласан байна.

Гэвч аймгийн эрүүл мэндийн байгууллагууд нь салбарын нэгдсэн үнэлгээг иргэдээс цаасаар болон цахим /QR код/-аар авч, нэгтгэл нь www.opendata.1313.mn сайтад байршиж байгаа талаар олон нийтэд мэдээлэх ажил дутмаг, судалгааг тогтмол авч хэвшээгүй байна.

График №-1: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн www.opendata.1313.mn сайтад бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудын амбулаториор үзүүлсэн иргэнээс авсан судалгааг харуулбал:




Графикаас харахад 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар эрүүл мэндийн 8 байгууллагын амбулаториор үйлчлүүлсэн нийт 1,243 иргэнийг судалгаанд хамруулсан байна.

Үүнээс Боржигон мандал өрхийн ЭМТ хамгийн олон буюу 814 иргэнийг судалгаанд хамруулсан бол Цагаандэлгэр сумын ЭМТ 1 иргэнийг судалгаанд хамруулжээ.

³ Энэхүү журмын 3.1.3.5-д заасан хэрэглэгчийн үнэлгээ нь эрүүл мэндийн салбарын хэрэглэгчийн санал бодлыг харгалзан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгох зорилготой. Хэрэглэгчийн үнэлгээг эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо хийж гүйцэтгэх ба салбарын нэгдсэн үнэлгээг Эрүүл мэндийн хөгжлийн төв хариуцан зохион байгуулна.

Хэвтэн эмчлүүлсэн нийт 238 иргэнийг судалгаанд хамруулжээ. Үүнээс хамгийн олон буюу 67 иргэнийг УАУНЭ хамруулсан бол Дэрэн, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвүүд 1 иргэнийг тус тус хамруулж, үлдсэн 11 байгууллага үйлчлүүлсэн иргэнийг судалгаанд хамруулаагүй байна.

График №-2: Эрүүл мэндийн салбаруудын хэвтэн эмчлүүлсэн иргэнээс авсан судалгааг графикаар харуулбал



Эрүүл мэндийн салбарууд нь амбулатори болон хэвтэн эмчлүүлэгчээс авсан сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан байдал хангалтгүй, цөөн иргэн хамрагдсан байна. Эмнэлгүүд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авч үнэлэх ажлыг дотооддоо зохион байгуулаагүй, үнэлгээний дүн, тайланг бодлого үйл ажиллагаандаа тусгахгүй, байгууллагын цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод мэдээлээгүй нь дээрх журмын 5.8.3⁴, 5.8.5⁵ дах заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн байгууллагууд нь дотооддоо өөрийн үзүүлж буй тусламж, үйлчилгээний чиглэлээр хэрэглэгчийн үнэлгээг тогтмол зохион байгуулаагүйгээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулах үр дагавартай байна.

Иймд эрүүл мэндийн байгууллагууд нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 тушаалаар батлагдсан журмын дагуу хэрэглэгчийн үнэлгээг дотооддоо тогтмол зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

1.2 Эрүүл мэндийн салбарын бодлогын баримт бичигт төлөвлөсөн ажил, арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаж, үнэлсэн боловч бодит үр дүнг тооцон ажиллаагүй байна.

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 37 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн тогтоосон байна. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Нийгмийн бодлогын хэлтэс нь аймгийн нийгмийн хөгжлийн стратеги, бодлогыг боловсруулах, төлөвлөх, боловсрол, соёл, спорт, аялал жуулчлал, шинжлэх ухаан, эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт, ядуурлыг бууруулах, хүн ам зүйн чиглэлээр явуулах бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр ЗГХЭГ-аас чиглэл ирүүлжээ.

Харин нийгмийн бодлогын эрүүл мэнд, хүн ам зүйн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод Эрүүл мэнд, хүн ам зүйн талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын өмнө хариуцна гэж тодорхойлсон байна.

⁴ Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж буй хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авахдаа тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг харгалзан асуумж боловсруулж гүйцэтгэнэ.

⁵ Эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэндийн хөгжлийн төв нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний дүнг байгууллагын цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод мэдээлнэ.

Гэвч 2025 оны 6 дугаар сараас хойш Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэнгүй байна. Засаг даргын тамгын газраас аймгийн Төрийн албаны зөвлөлд төрийн албан хаагчийг шилжүүлэн ажиллуулах зарыг 2 удаа зарлуулсан боловч ажиллах хүний материал ирүүлээгүй байна.

Энэ нь эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн байхгүйгээс салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилт, хэрэгжиж байгаа хөтөлбөр, тайлан мэдээ, судалгааг нэгтгэх, байгууллага хоорондын уялдаа холбоог хангуулан ажиллахад хүндрэл үүсэж, бодлого төлөвлөлт, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа эрүүл мэндийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах, хяналт тавих ажил хийгдэхгүй байх, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо алдагдах үр дагаврыг бий болгож байна.

Иймд Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн салбар хариуцсан мэргэжилтнийг ажиллуулж, заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, эрүүл мэндийн салбарын байгууллагуудыг арга зүйгээр хангах, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн Эрүүл мэндийн газар Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд авч хэрэгжүүлэх арга, хэмжээний эрүүл мэндийн салбарын ажил, арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заалт болгон хэрэгжүүлэхээс гадна харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд тусган, хэрэгжилтэд хяналт тавин арга зүйгээр ханган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргатай Эрүүл мэндийн газрын дарга хамтран ажиллах гэрээ байгуулж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж байгаа бол сумдын Засаг даргатай сумын эрүүл мэндийн төвийн дарга хамтран ажиллах гэрээ байгуулж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган тайлагнаж байна.



Эрүүл мэндийн газар сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, сумын Засаг даргатай байгуулсан гэрээнд улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, мобайл технологийг нэвтрүүлэх, гэрийн эргэлт, хяналтын үзлэгийг өргөжүүлэн тусламж, үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг бууруулах зэрэг арга, хэмжээг тусган хамтран ажилласан байна.

Мөн Эрүүл мэндийн газраас ажлын хэсэг томилон харьяа эрүүл мэндийн байгууллагуудад жил бүр бодлогын баримт бичиг болон байгууллагын чиг үүрэг бусад нэмэлт үнэлгээг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу удирдамж, төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагааны явцын хяналт, шалгалтыг хийж ажиллажээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын ХШҮХ-ээс эрүүл мэндийн газрын үйл ажиллагаанд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу жил бүр хяналт, шинжилгээ, үнэлгээг хийсэн байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээг хийхдээ аймгийн эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа хууль, тогтоомж болон бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, Эрүүл мэндийн яам болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээг хэрэгжүүлж ажилласан байдал зэрэг салбарын хэмжээгээр үнэлэлт өгчээ.

Хүснэгт №-4 АЗДТГ-ын ХШҮХ-ийн 2023, 2024 оны үнэлгээг шалгуур үзүүлэлт бүрээр харуулбал

№	Шалгуур үзүүлэлт	2023 оны жилийн эцсийн үнэлгээ	2024 оны жилийн эцсийн үнэлгээ
1	Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ	94.0	85.0
2	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт	82.3	-

3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	47.2	66.6
4	Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ	94.4	78.8
5	Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ	94.0	94.2
6	Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хэрэгжилтийн үнэлгээ	-	87.5
7	Мэдээллийн ил тод нээлттэй байдлын үнэлгээ	95.0	98.0
8	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	100	100
9	Байгууллагын дотоод үйл ажиллагаа хэрэгжилтийн үнэлгээ	84.3	74.1
10	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ	-	78.6
11	Хөндлөнгийн үнэлгээ	91.0	85.3
12	Тухайн жилд зохион байгуулсан онцлох ажлын үнэлгээ	85.5	81.6
	Нийт	85.7	84.5

Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс 2023 оны үйл ажиллагааг 10 үзүүлэлтээр, 2024 оны үйл ажиллагааг 11 үзүүлэлтээр үнэлж, дүгнэн үнэлгээний дүнг аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулсан байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр хамгийн сайн биелэлттэй нь шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ 100 хувь үнэлэгдсэн бол эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээний хэрэгжилт 47.2-66.6 хувь буюу хамгийн муу үнэлэгдсэн байна. Үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээний дундаж 2023 онд 85.7 хувьтай, 2024 онд 84.5 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1.2 хувиар буурсан байна.

Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан 2023, 2024 оны гэрээний хэрэгжилт, үйл ажиллагааны гүйцэтгэлд Эрүүл мэндийн яамнаас хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээг хүснэгтээр харуулбал:


Хүснэгт №-5 Эрүүл мэндийн яамнаас хийсэн үнэлгээний дүн

№	Үзүүлэлт	2023	2024
1	Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	84.5	-
2	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	85.7	-
3	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт	70.2	65.2
4	Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт	90	-
5	Хэрэглэгчийн үнэлгээ	84.8	-
6	Хамтран ажиллах гэрээний биелэлт	-	89.6
7	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ	-	80
	Дундаж үнэлгээ	81.3	78.3

*Эх сурвалж: Эрүүл мэндийн газар

Эрүүл мэндийн яамнаас үнэлсэн үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээний дундаж 2023 онд 81.3 хувьтай, 2024 онд 78.3 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 3.0 хувиар буурчээ.

График №-3 АЗДТГ болон Эрүүл мэндийн яамны 2022-2024 оны ХШҮ-ний дүнг харуулав.




чанарын хэрэгжилтийн үнэлгээтэй холбоотой байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээний дүгнэсэн байдлаас харахад 2022 онд 78.4 хувь, 2023 онд 85.5 хувь, 2024 онд 84.5 хувь байгаа сүүлийн 2 жил сайн үнэлэгдсэн байна. Харин эрүүл мэндийн яамны хяналт, шинжилгээ үнэлгээгээр 2024 онд буурсан үзүүлэлттэй байгаа нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний

Мөн эрүүл мэндийн салбарын нэг гол үзүүлэлт болох эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтэд аймгийн засаг даргын Тамгын газар болон Эрүүл мэндийн яамны ХШҮ-ээс хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн үнэлгээг авч үзлээ.

График №-4 Эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтэд 2022-2024 онд хийсэн ХШҮ-г харуулав. *Эх сурвалж: Эрүүл мэндийн газар




Графикаас харахад аймгийн засаг даргын Тамгын газрын эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтэд хийсэн хяналт, шинжилгээ үнэлгээний дүн 70.4-75.1 хувьтай үнэлэгдэж 2024 онд өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Харин Эрүүл мэндийн яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үнэлгээний дүн 2022 онд 75.8 хувь, 2023 онд 70.4 хувь, 2024 онд 65.2 хувиар үнэлэгдэж, үнэлгээ жил бүр буурсан байна. Эрүүл мэндийн яамны 2024 оны хяналт шинжилгээ үнэлгээний

тайланд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын сайжруулах талаар чиглэл, зөвлөмж өгөгдсөн боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Аудитаар аймгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны санал асуулгад 15 төрлийн асуумжаар 401 иргэнийг хамруулснаас, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний холбоотой дараах 2 асуултыг авч үзлээ.

“Та аймгийнхаа эмнэлгүүдээс эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ авч чаддаг уу?” гэсэн асуултад 56.3 хувь буюу 226 хүн авч “**Чаддаг**”, 175 хүн буюу 43.7 хувь нь авч “**Чаддаггүй**” гэж хариулсан нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах шаардлагатай гэж иргэд сэтгэл ханамжийн судалгаагаар үнэлсэн байна.

График №-5 Эмнэлгүүдээс эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ авч чаддаггүй гэж хариулсан байдлыг харуулбал:



Эмнэлгийн ажилтнуудын зан харилцаа муу, хүнд сурталтай гэсэн хариултад хамгийн олон буюу 79 хүн хариулсан бол эмнэлгийн орчны тохижилт тааруу, тав тух муутай гэж 10 хүн хариулсан байна.

Иймд аймгийн Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн байгууллагуудын ажлыг сайжруулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтэд анхаарч, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.



БҮЛЭГ 2. ОРОН НУТАГТ НЭН ШААРДЛАГАТАЙ ЭМЧ, СУВИЛАГЧ, ТУСАЙ МЭРГЭЖИЛТНИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ БОЛОН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТАД ХАМРУУЛЖ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛИЙГ НЭМЭГДҮҮЛСЭН БАЙНА.

2.1 Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг тооцож, чиглэл, арга зүйгээр хангахгүй байна.

УИХ-ын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Алсын хараа-2050”-д эрүүл мэндийн салбарын хөгжлийн зорилгыг “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ” хэмээн тодорхойлсон байдаг.

Уг урт хугацааны бодлогын баримт бичигт нийцүүлэн баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хүний хөгжлийн зорилгын хүрээнд эрүүл мэндийн салбарт эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийх зорилтыг дэвшүүлж, 8 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна” гэж тусгажээ.

Дээрх бодлогын баримт бичигт тусгагдсан хүний хөгжлийн зорилт, арга хэмжээг хангах бодлогыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр А/379 дүгээр тушаалаар “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих арга хэмжээний 2025-2028 оны төлөвлөгөө” нэртэйгээр батлагджээ. Энэ нь “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2018-2021 хөгжүүлэх бодлого” хэрэгжиж дууссанаас хойш 4 жилийн дараа батлагдсан байна.

Аймгийн хэмжээнд боловсруулан хэрэгжүүлж байгаа Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн болон эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө, аймгийн хүний нөөцийг 2021-2025 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн талаар зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт №-6 Бодлогын баримт бичигт эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн талаар хэрхэн тусгасан байдал

Бодлогын баримт бичиг	Сургалт, хөгжлийн чиглэлээр	Хүний нөөцийн хангалтын чиглэлээр	Нийгмийн баталгааг хангах чиглэлээр	Нийт
Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	1	3	1	5
Аймгийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө	1	1	1	3
ЭМГ-ын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө	5	11	7	23

Дундговь аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг дэмжих, нийгмийн баталгааг хангах, сургалт хөгжлийн чиглэлээр нийт 5 арга хэмжээг төлөвлөсөн ба хэрэгжилтийг 100.0 хувьтай дүгнэж “Бүрэн хэрэгжсэн” гэж үзсэн байна.

Аймгийн эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд мэргэшсэн, чадавхтай, мэргэжлийн хүний нөөцийг хангах зорилтыг дэвшүүлж нийт 23 арга, хэмжээг төлөвлөн баталжээ.

Хүснэгт №-7: Эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал /Сая.төг/

Эрүүл мэндийн газар	2021-2024 оны төлөвлөгөө	Төсөвлөсөн санхүүжилт	Хэрэгжсэн арга хэмжээний тоо	Зарцуулсан санхүүжилт	Хэрэгжилтийн дундаж хувь	Санхүүжилтийн зөрүү
---------------------	--------------------------	-----------------------	------------------------------	-----------------------	--------------------------	---------------------

Сургалт, хөгжил	5	84.2	5	171.2	100	(87.0)
Хүний нөөцийн хангалт	11	144.8	11	132.5	99.1	12.3
Нийгмийн баталгааг хангах	7	1,374.9	5	1,156.8	71.4	218.1
Нийт	23	1,603.9	21	1,460.5	90.2	143.4

Эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан хүний нөөцтэй холбоотой 23 арга хэмжээнд нийт 1,603.9 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөгдсөн бол гүйцэтгэлээр 1,460.5 сая төгрөгийн санхүүжилтээр 21 арга, хэмжээ бүрэн хэрэгжиж, нийт дундаж үнэлгээ 90.2 хувьтай байна.

Сургалт, хөгжлийн чиглэлээр төлөвлөсөн арга, хэмжээ бүрэн хэрэгжсэн бол нийгмийн баталгааг хангах чиглэлээр төлөвлөгдсөн 2 арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Хэрэгжээгүй 2 арга хэмжээний 1 нь тогтвор суурьшилтай ажиллаж буй албан хаагчдад мөнгөн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ байсан боловч санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүйн улмаас хэрэгжээгүй. Харин “Ажилчдын ажиллах орчныг сайжруулах, эмнэлгийн ажилчдын хоолны газар, эмнэлгийн ажилчдын амралт сувиллын газрыг бий болгох” арга хэмжээг хэрэгжүүлэхээр жил бүрийн төлөвлөгөөнд тусгасан ч хэрэгжээгүй байна.

Төлөвлөсөн ажил, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй нь санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тооцоолоогүй, харьяа байгууллагуудын саналыг аваагүй, орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагыг бүрэн судлаагүй төлөвлөсөнтэй холбоотой байна.

Төрийн байгууллага албан хаагчийнхаа сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх талаар Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3⁶-т тодорхой заасан байна. Хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэн эрүүл мэндийн байгууллагууд ажилтны сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө болон хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

Аудитын хугацаанд зарим сумын эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж, ажлын талбарт ажиллалаа. Ажиллах үеэр тухайн байгууллагын хүний нөөцийн талаар хэрэгжүүлж байгаа баримт бичгийн төлөвлөлт, тайлагналтай танилцсан бөгөөд дараах нийтлэг заалтуудыг тусган хэрэгжүүлжээ. Үүнд:

- Байгууллагын албан хаагчдын хүрээнд дотоод сургалт зохион байгуулах;
- Шинээр орсон ажилчдыг дадлагажуулах ажлыг зохион байгуулах;
- Ажилчдыг төрийн болон салбарын шагналд тодорхойлох;
- Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах.

Харин албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр дараах заалтуудыг нийтлэг тусгажээ. Үүнд:

- Албан хаагчдын цалин халс, нөхөх төлбөр, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу олгох;
- Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах;
- Эмч, сувилагч, албан хаагчдыг шаардлагатай эмнэлгийн хамгаалах хувцас хэрэглэлээр хангах;
- Ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, идэвхжүүлэх тэмцээн уралдаан зохион байгуулах.


⁶ 55.3.Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

Дээрх төлөвлөгөөний хэрэгжилтийг бүтэн жилээр гарган тайлагнаж байгаа ч үр дүнг тооцдоггүй, дүн шинжилгээ хийдэггүй, гүйцэтгэлд үндэслэн хүрэх түвшнийг тодорхойлдоггүй, жил бүр ижил ажил, арга хэмжээг төлөвлөдөг байдал нийтлэг байгаа нь энэ хөтөлбөр, төлөвлөгөөг нэр төдий хийдэг, ач холбогдол өгдөггүй нь харагдаж байна.

Аймгийн Эрүүл мэндийн газар харьяа байгууллагуудын хүний нөөцийн болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд нэгдсэн бодлого арга зүйгээр хангадаггүй, хэрэгжилтийг нэгтгэж дүгнэхгүй байна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Эрүүл мэндийн яамнаас аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаа болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд дараах 5 үндсэн чиглэлийн хүрээнд ХШҮ-г гүйцэтгэн тайлан, зөвлөмжийг хүргүүлжээ.

График №-6: Эрүүл мэндийн яамнаас 2021-2024 онуудад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн



Салбарын үйл ажиллагааны нийт үнэлгээ болон хүний нөөцтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилтийн хувь жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

Мөн Дундговь аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс нийт агентлагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлан, дүгнэлт гаргаж зөвлөмж өгсөн байна.

Аймгийн хэмжээгээр 2022 оны төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 94.2 хувьтай үнэлэгдсэн бол эрүүл мэндийн салбарын хэрэгжилт 95.1 хувьтай буюу үр дүнтэй гэж үнэлэгдсэн ба тухайн жилийг “Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарлажээ.

Харин 2024 онд аймгийн хэмжээгээр албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ 86.8 хувь үнэлэгдсэн бол эрүүл мэндийн салбар 87.5 хувьтай үнэлэгдсэн.

Эрүүл мэндийн газрын Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтнээр ахлуулсан баг жил бүр анхан шатны болон лавлагаа шатлалын эмнэлгүүдийн үйл ажиллагаанд түүврээр хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийж зөвлөмж өгч ажиллажээ.


Гэвч тус хяналт-шинжилгээ, үнэлгээгээр хүний нөөцийг дэмжих төлөвлөгөө болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрүүдэд чиглэсэн хяналт хийхдээ үнэлгээ өгдөггүй, үр дүнг тооцоогүй байна.

Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг тооцож, чиглэл, арга зүйгээр хангаж ажиллах шаардлагатай байна.

2.2 Аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт сүүлийн жилүүдэд тогтвортой байж, сул орон тоо 2025 оны 10 дугаар сарын байдлаар 70 болж буурсан үзүүлэлттэй байна.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2024 онд хийгдсэн “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын дүгнэлтээр 2023 оны байдлаар аймгийн хэмжээнд хөдөө аж ахуй, нийгмийн хамгаалал болон эрүүл мэндийн салбарыг хүний нөөц хамгийн дутагдалтай гэж дүгнэжээ.

График №-7: Эрүүл мэндийн салбарт 2025 оны 10 дугаар сарын байдлаар ажиллаж буй албан хаагчдын тоо




Дундговь аймгийн хэмжээнд 2025 оны 10 дугаар сарын байдлаар эрүүл мэндийн салбарт нийтдээ 587 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүний 38.2 хувь буюу 224 хүн захиргаа, удирдлага болон бусад дэмжих албан хаагчид байна. Нийт албан

хаагчдын 19.9 хувь нь их эмч, 6.0 хувь нь бага эмч, 2.6 хувь нь уламжлалт анагаах ухааны их эмч байгаа бол 23.2 хувь нь сувилагч байна.

Монгол улсын хэмжээн дэх их эмч болон сувилагчийн харьцааг 2024 оны байдлаар (Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо www.1212.mn) тооцоолоход улсын түвшинд 1:0.9, Улаанбаатар хотын түвшинд 1:0.8 байгаа бол Дундговь аймгийн хувьд (Эх сурвалж: Аймгийн эрүүл мэндийн газар) 1:1 байгаа нь улсын дунджаас өндөр буюу эмч сувилагчийн харьцаа боломжит түвшинд байгааг харуулж байна.

График №-8: Салбарын 2021-2025 оны хүний нөөцийн байдал



Эрүүл мэндийн газраас Дундговь аймгийн эрүүл мэндийн салбарын сул ажлын байрны мэдээллийг жил бүр гаргадаг. Графикт 2021-2025 оны 10 дугаар сарын байдлаарх хүний нөөцийн хангалтын хувь болон сул орон тооны мэдээллийг харууллаа.

Хүний нөөцийн хангалтын хувийг тооцоолохдоо ажиллаж буй албан хаагчийг батлагдсан орон тоонд харьцуулан тооцсон бөгөөд түр орлон болон хавсран гүйцэтгэж байгаа тохиолдлыг тухайн албан тушаалын орон тоог хангагдсан гэж үзсэн болно.

Хүний нөөцийн хангалт 2021 онд 95.9 хувь байсан бол 2025 оны 10 дугаар сарын байдлаар 91.4 хувь болж буурсан байна.

Эрүүл мэндийн салбарт дутагдалтай байгаа эмч, ажилтны тоо 2024 онд 99 байсан бол 2025 оны 10 дугаар сарын байдлаар 70 болж буурсан байна. Энэ нь 2024-2025 онд 21 их эмчийн сул орон тоог нөхөгдсөнтэй холбоотой байна.

Аймгийн хэмжээнд нийт сул байгаа 70 орон тооны 55.7 хувь буюу 39 сул орон тоог албан хаагчид хавсран гүйцэтгэж, 3 орон тоонд түр орлон гүйцэтгэгч ажиллаж байна.

Сумдын эрүүл мэндийн төвүүдэд их эмч хамгийн их дутагдалтай байгаа бөгөөд одоогийн байдлаар 19 их эмч, 14 сувилагч шаардлагатай байна. Орон нутгаас сургалтын төлбөрийн дэмжлэг авч суралцаж байгаа оюутнуудаас 2026 онд 5, 2027 онд 13 суралцагч төгсөхөөр байна.

Хүснэгт №-8: Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний нэмэгдсэн, хасагдсан судалгаа

№	Нэмэгдэж, хасагдсан шалтгаан	2021	2022	2023	2024	Нийт
1	Нэмэгдсэн	183	145	164	140	632
	Төгсөж ирсэн	33	27	21	21	102
	Шинээр ажилд орсон	110	90	103	99	402
	Шилжиж ирсэн	32	16	15	8	71
	Жирэмсний болон хүүхэд асрах чөлөөнөөс орсон	10	12	25	12	59
2	Хасагдсан	154	181	153	112	600
	Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн	83	105	74	64	326
	Эрүүл мэндийн байгууллага хооронд шилжсэн	6	11	11	3	31
	Тэтгэвэрт гарсан	31	21	18	16	86
	Нас барсан	1	0	1	2	4
	Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө авсан	27	43	31	20	121
	Бусад шалтгаанаар /халагдсан/	6	1	18	7	32


*Эх сурвалж: Эрүүл мэндийн газар

Хүснэгтээр 2021-2024 оны эрүүл мэндийн салбарын ажилчдын шилжилт хөдөлгөөнийг харууллаа. Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний харьцаа 1:0.9 буюу ажилд орсон албан хаагчдын тоо ажлаас гарсан албан хаагчдаас өндөр байгаа юм.

Ажлаас чөлөөлөгдсөн эмч, ажилтны тоо 2022 онд хамгийн өндөр буюу нийт 181 байсан бөгөөд 105 ажилтан өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн байна. Ажлаас гарсан албан хаагчдын дийлэнх хувь нь сувилагч болон бусад албан хаагчид байсан бөгөөд “Ковид-19” цар тахалтай холбоотой ажлын ачааллаас шалтгаалан ажлаас чөлөөлөгдсөн байна.


График №-9: 2021-2025 онуудад ажлаас чөлөөлөгдсөн болон ажилд орсон эмч, сувилагчийн тоо

2021-2023 онд жилд дунджаар 45 их эмч ажлаас гарсан бөгөөд дийлэнх хувь нь өөрийн хүсэлтээр чөлөөлөгджээ. Эмч нар уурхайн компанид ажиллах нь түгээмэл байгаа бөгөөд энэ нь цалин, урамшуулал өндөр, ажлын ачаалал бага, ажилчдын нийгмийн баталгааг сайн хангаж байгаатай холбоотой байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 2 дугаар хүснэгтээс үзнэ үү).



Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалын дагуу сувилагч, тусгай мэргэжилтний төрөлжсөн мэргэшлийн сургалт, мэргэжил дээшлүүлэх сургалт, их эмчийн үндсэн мэргэшлийн сургалт буюу резидент, төрөлжсөн мэргэшлийн сургалт болон мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг сайдын төсвийн багцад тусгаж жил бүр зохион байгуулдаг.

График №10: 2021-2025 онуудад төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгаа



Дээрх сургалтад 2021-2025 онд нийт 128 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдаж мэргэжил дээшлүүлсэн байна.

Сувилагч, тусгай мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалтаар эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан, гемодиализийн сувилагч, мэс заслын сувилагч болон эх баригч тусгай мэргэжлээр нийт 7 албан хаагч тус тус мэргэжил дээшлүүлсэн байна.

Үндсэн мэргэшлийн сургалт буюу резидент эмч нарын сургалтад 2021-2025 онуудын хооронд нийт 24 албан хаагч хамрагдсанаас 2023 онд хавдрын 1 эмч бэлтгэгдсэн байна. Төрөлжсөн мэргэшлийн сургалтад нийт 18 их эмч хамрагдсанаас 2023 онд гавал, тархины мэс засал, сэтгэл засал, 2024 онд бөөр судлал, 2025 онд хүүхдийн зүрх болон хавдрын хими эмчилгээгээр тус бүр нэг их эмчийг анх удаа төрөлжүүлж, мэргэшүүлжээ.


Харин мэргэшил дээшлүүлсэн 23 их эмчээс хэвлийн хөндийн хэт авиа оношилгоогоор 2022 оноос хойш жил бүр 2-3 их эмч, нийт 9 их эмч мэргэшил дээшлүүлсэн бол 2025 онд хэвлийн хөндийн дурангийн мэс засал, хавдрын хими эмчилгээний найруулга зүй чиглэлээр мөн анх удаа мэргэшил дээшлүүлсэн байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 4-8 дугаар хүснэгтээс үзнэ үү)

Хавдрын химийн эмч, сувилагчийг төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамруулж, Нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн хавдрын тасаг шинээр нээсэн нь орон нутагтаа хямд өртгөөр хавдрын хими эмчилгээг цаг алдалгүй авах боломжтой болжээ.

Анхан болон лавлагаа шатны ЭМБ-аас 2023-2025 онуудад нийт 60 эмч, эмнэлгийн ажилтан, албан хаагчид улс, орон нутгийн төсвийн санхүүжилтээр гадаад сургалтад хамрагдсан байна.

Монголын Өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооноос 2024 онд БНХАУ-ын Эрээн хотод зохион байгуулсан өрхийн ЭМТ-ийн туршлага судлах говийн бүсийн чуулганд аймгийн өрхийн ЭМТ-ийн нийт 21 албан хаагчийг оролцуулжээ.

График №-11: Гадаад сургалтын талаар мэдээлэл (2023-2025 он)



*Эх сурвалж: Эрүүл мэндийн газар

Эрүүл мэндийн яам, ОУ-ын байгууллагуудтай хамтран 2024-2025 онд Нэгдсэн эмнэлгийн дотрын 1 эмчийг Тайланд улсад, бөөрний 1 эмчийг Солонгос улсад туршлага судлуулж, ур чадварыг сайжруулсан байна. Мөн БНХАУ-ын Хөх хотод зохион байгуулагдсан “Хөхний хавдрын урьдчилан сэргийлэлт, хяналт олон улсын хурал”-д Нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн эмч, эс судлагч эмч нарыг хамруулжээ.


Мөн БНХАУ-д “Сувилагчийн ур чадварыг дээшлүүлэх сургалт”-д сумдын эрүүл мэндийн төвийн 5 эмч, сувилагч, мэргэжилтнийг, БНСУ-д “Сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтний чадавхыг дээшлүүлэх, сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах” сургалтад Нэгдсэн эмнэлгийн 2, сумдын эрүүл мэндийн төвийн 5 эмч, сувилагчийг хамруулсан байна.

Сайн туршилага: Аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрөөс 2025 онд БНХАУ-ын Бээжин хотод Нэгдсэн эмнэлгийн мэс заслын 2 эмчийг сургалт, туршилага судлуулахад тус бүр 3.1 сая, Энэтхэг улсад зохион байгуулсан хуралд оролцсон 1 эмчид 3.0 сая, 2024 онд Индонез улсад зохион байгуулсан сургалтад хамрагдсан 1 эмчид 2.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Эдгээр төсвийн санхүүжилтээр гадаад сургалтад хамрагдаж, туршилага хуримтлуулсан эмч, эмнэлгийн ажилтнууд бүгд орон нутагтаа ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан "Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", Монгол Улсын Ерөнхий сайдын “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг 2021 оноос орон нутагт хэрэгцээтэй боловсон хүчнийг шинээр бэлтгэх, хангалтыг нэмэгдүүлэх, ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгааг хангах зэрэг зорилгоор боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн.


График №-12: "Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-өөс 2021-2025 онд олгосон дэмжлэг



Уг хөтөлбөрөөр 2021-2025 онуудын хооронд аймгийн эрүүл мэндийн салбарт нийт 195 оюутан, албан хаагчдад 502.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд олгосон дэмжлэгийн 48.2 хувь буюу 242.2 сая төгрөгийг 2025 онд олгожээ. 2021-2024 онуудад аймгийн ЗДТГ-ийн нийгмийн бодлогын хэлтэс ЭМГ-аас дэмжлэг авах албан хаагчдын санал авч, тус саналын дагуу шаардлага хангасан албан

хаагчдад дэмжлэг олгож байсан бол 2025 онд байгууллагуудаас холбогдох материалуудыг авч дэмжлэг олгожээ.

График №-13: "Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-өөс олгосон дэмжлэгийг төрлөөр харуулав.



Нийт олгосон дэмжлэгийн 39.0 хувь нь албан хаагчдын нийгмийн баталгааг хангах байр, орон сууц, гэрийн дэмжлэг, 23.0 хувь нь оюутны сургалтын төлбөрийн дэмжлэг, 21.0 хувь нь нэг удаагийн урамшуулал байна.

Хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг авсан 53 оюутнаас 26 нь суралцаж байна. Харин бусад 27 хүний 20 албан хаагч орон нутагтаа ажиллаж байгаа бол 3 нь гэрээний дүнг эрүүлэн төлж, 1 албан хаагч ажиллаж байгаад дахин суралцахаар гэрээ байгуулж, 3 хүн гэрээний үүргээ биелүүлээгүй байна. Эдгээр 3 хүнээс 2 нь эрүүл мэндийн болон хүүхэд төрүүлсэн шалтгаанаар ажиллахгүй байгаа бол 1 нь өөрийн хүсэлтээр ажлаас гарсан байна.

Нэг удаагийн шагнал урамшууллыг 2021 болон 2025 онуудад албан хаагчдад олгосон бөгөөд 2021 онд Ковид-19 цар тахлын үед голомтод ажилласан анхан шатны эрүүл мэндийн төвийн 18 албан хаагчдад нийт 9.0 сая, 2025 онд албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах сорилгоор 2 жил ажилласан сумдын 18 их эмчид 48.0 сая, салбартаа 34-42 жилийн турш тасралтгүй ажиллаж буй 18 эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд 48.0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус олгосон байна.

Хурал болон тэмцээн, уралдааны дэмжлэгийг зөвхөн 2025 онд олгосон бөгөөд “Дэлхийн эмч нарын өдөр” болон “Сувилагч нарын өдөр”-т зориулсан онол практикийн бага хурал зохион байгуулж, шилдэг судалгааны илтгэлийг шалгаруулж 3.2 сая төгрөгөөр шагнажээ. Мөн сувилагч, тусгай мэргэжилтнүүд дунд ажил, мэргэжлийн багийн уралдааныг зохион байгуулж 7.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрөөс олгож буй албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дэмжлэгээс гадна сумдын ЗДТГ-аас сумынхаа эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, эмчийн хангалтыг нэмэгдүүлж, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор хөтөлбөр, арга хэмжээнүүдийг боловсруулан хэрэгжүүлсэн байна.

Сайн туршлага: Эрдэнэдалай, Дэлгэрхангай сумд дутагдалтай байгаа эмч, ажилтны хангалтыг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор 7 эмчтэй хамтран ажиллах гэрээ байгуулан сумандаа ажиллуулж байна. Гэрээнд орон байраар хангах, гэр бүлийн хүнийг ажлын байраар хангах, буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх зэрэг нийгмийн асуудлыг шийдвэрлэхээр тусгажээ.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн гүйцэтгэх удирдлагыг томилж, чөлөөлөх зохицуулалтыг Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4⁷ дэх заалтаар эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.7⁸-д зааж өгчээ. Гэвч эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулаагүй байгаа нь дээрх хуулийн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн одоогийн удирдлагыг томилохдоо Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5⁹ дахь заалтыг үндэслэн аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 16-

⁷ Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

⁸ Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл нь өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүн, тухайн эмнэлгийн хамт олныг төлөөлөх гурван гишүүн, олон нийтийг төлөөлөх гурван гишүүнтэй байна.

⁹ Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албаны дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

ны өдрийн Б/27 дугаар тушаалаар түр орлон гүйцэтгэгчийг томилсон нь Эрүүл мэндийн тухай хуулийг зөрчсөн томилгоо болсон байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1¹⁰-д албан тушаалын тодорхойлолтыг томилох эрх бүхий этгээд батлахаар заасан байна. Гэвч Нэгдсэн эмнэлгийн даргыг томилох төлөөлөн удирдах зөвлөл байгуулагдаагүй учир ажлын байрны тодорхойлолтыг батлах эрх бүхий этгээд байхгүй нөхцөл байдал үүссэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийг төлөөлөх гурван гишүүнийг сонгох ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, аймгийн Засаг даргын 2022 оны А/425 дугаар захирамжаар олон нийтийг төлөөлөх гурван гишүүнийг батламжилсан байна. Эрүүл мэндийн яамнаас ажлын хэсэг орон нутагт ирж эмнэлгийн хамт олныг төлөөлөх гурван гишүүнийг 2023 онд сонгон шалгаруулжээ.

Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн А/267 дугаар захирамжаар олон нийтийг төлөөлөх гурван гишүүнийг сонгон шалгаруулах хороог дахин байгуулж, 2022 оны захирамжийг хүчингүй болгосон байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн эмнэлгийн өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүнийг огт сонгон шалгаруулаагүй байна.

Иймд Нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн гишүүнийг холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулан зөвлөлийг байгуулж, Эрүүл мэндийн тухай хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, эмнэлгийн даргыг хуулийн дагуу томилох шаардлагатай байна.

Төрийн үйлчилгээний удирдах албан тушаал болох сумдын ЭМТ-ийн даргын томилгооны хувьд Өндөршил, Цагаандэлгэр, Гурвансайхан, Хулд болон Баянжаргалан сумдын Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3¹¹, 43.4¹²-т заасныг тус тус зөрчин томилсон байна.

Иймд холбогдох хууль, журмын дагуу төрийн үйлчилгээний удирдах ажилтны сонгон шалгаруулалт буюу тусгай шалгалтад тэнцсэн иргэнийг сумын ЭМТ-ийн даргын албан тушаалд томилж, томилгооны зөрчлийг арилгах шаардлагатай байна.

Аудит хийх үеийн байдлаар эрх бүхий этгээдийн гаргасан буруутай шийдвэрийн улмаас эрүүл мэндийн салбарын 2 байгууллагын төсөвт 13.3 сая төгрөгийн хохирол учирсан байна.

Үүссэн хохирлыг байгууллагын санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн ч барагдуулаагүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1¹³-д заасныг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт №-9: Төсөвт учирсан хохирол, түүнийг барагдуулсан байдал /Сая.төг/

Байгууллагын нэр	Нийт нөхөн олговрын дүн	Хохирол барагдуулсан байдал		Төсөвт үүссэн хохирол	Үүссэн хохирлыг барагдуулсан байдал	Төсөвт учирсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авсан эсэх
		Буруутай албан тушаалтан	Байгууллага			
НЭмнэлэг	13.9	8.6	5.3	5.3	5.3	Аудитын явцад барагдуулсан.

¹⁰ Албан тушаалын тодорхойлолтыг томилох эрх бүхий этгээд шийдвэр гаргаж, албан тушаал тус бүрээр батална.

¹¹ Энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх;

¹² Албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан хаагч нь үндсэн албан тушаалаасаа чөлөөлөгдөхгүйгээр албан үүргийнхээ зэрэгцээ түр орлох албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг хариуцна.

¹³ Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.

Хулд сумын ЭМТ	8.0	-	8.0	8.0	-	Буруутай шийдвэр гаргасан этгээдээр байгууллагыг хохиролгүй болгох шүүхийн шийдвэр гарсан
Дүн	21.9	8.6	13.3	13.3	5.3	-

Эрүүл мэндийн даргын шийдвэрээр албан тушаал буурсан ажилтанд нийт 13.9 сая төгрөгийг олгохоор шүүх шийдвэрлэсэн байна. Шийдвэр гаргасан албан тушаалтан 8.6 сая төгрөгийг хувиасаа нэхэмжлэгчид олгосон бол 5.3 сая төгрөгийг байгууллагын төсвөөс олгожээ. Байгууллагаас олгосон нөхөн төлбөрийг барагдуулаагүй байсныг аудитын явцад төлүүлж зөрчлийг арилгасан.

Мөн Хулд сумын ЭМТ-ийн даргын шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн албан тушаалтанд 8.0 сая төгрөгийг олгохоор шүүх шийдвэрлэж байгууллагын төсвөөс олгосон байна.

Байгууллагад учирсан хохирлыг буруутай шийдвэр гаргасан этгээдээр гаргуулахаар нэхэмжилж шүүх нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн ч төлөгдөөгүй байх тул авлагыг барагдуулах хугацаатай албан шаардлага хүргүүлээ.



БҮЛЭГ 3. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН САНХҮҮЖИЛТЭД ТАВЬСАН ХЯЗГААРЛАЛТ, НЭХЭМЖЛЭЛИЙН ХАСАГДАЛ ӨНДӨР БАЙГАА НЬ БАЙГУУЛЛАГА ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ХЭВИЙН ЯВУУЛАХАД ХҮНДРЭЛ ҮҮСГЭЖ БАЙНА.

3.1. Анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн орлогыг бүрэн авч чадахгүй байна.

Анхан шатны ЭМБ-ууд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн орлогыг бодитой төлөвлөөгүй, түүнд ЭМГ-аас тавих хяналт сул байна.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Шинэчлэлийн хүрээнд ЭМБ-уудаас үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардал, санхүүжүүлэх төлбөрийн арга, санхүүжилтийг тооцох журмыг ЭМДҮЗ-ийн 2022 оны 01, 05 дугаар тогтоолоор шинэчлэн тогтоож, лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг зөвхөн гүйцэтгэлд суурилсан, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг нэг иргэнээр тооцсон болон гүйцэтгэлд суурилсан төлбөрийн аргаар ЭМДС-аас санхүүжүүлэхээр болжээ.

Анхан болон лавлагаа шатны эмнэлгүүд ЭМДС-аас авах санхүүжилтийн орлогыг өмнөх жилийн үйлчилгээний гүйцэтгэлд тулгуурлан, тухайн жилд хүчин төгөлдөр мөрдөх ЭМДҮЗ-ийн тогтоолоор баталсан оношны хамааралтай бүлэг, тохиолдолд суурилсан төлбөрийн арга, тарифын дагуу төлөвлөхөөр зохицуулагдсан.

Харин нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хүн амын эрсдэлийн бүлгийн коэффициент болон тухай эмнэлэгт харьяалалтай багийн хүн амын тоонд үндэслэн нэг иргэнд ногдох зардлаар тооцохоор журамд заасан байна.

Аймгийн төвийн хоёр лавлагаа шатны эмнэлэг 2023–2025 оны ЭМДС-ийн санхүүжилтийн орлогыг ЭМЯ-ны загвар маягтын дагуу тусламж, үйлчилгээний төрөл, оношны бүлэг, төлбөрийн хэмжээгээр тооцож, ЭМГ-т хүргүүлэн баримтжуулсан байна.

Харин анхан шатны эмнэлгүүдийн орлого, зардлын төлөвлөлт хангалтгүй байна. ЭМЯ-ны загвар маягтын дагуу төсвөө бэлтгэн ЭМГ-т нэгтгүүлдэг гэж мэдээлсэн боловч аудитын шалгалтаар Баянжаргалан, Сайнцагаан сумын ЭМТ-үүдийн 2024–2025 оны төсвийн төсөлд

зөвхөн зардлыг төлөвлөж, орлогыг тусламж үйлчилгээний төрлөөр нарийвчлан тооцоогүй, төслийн хэвлэмэл баримт бүрдээгүй байв.


Мөн Эрдэнэдалай, Хулд сумдын хувьд 2023–2025 оны төсвийн төслийн цахим болон цаасан баримт огт байхгүй байв.

Аудитын явцад аймгийн ЭМГ-аас анхан шатны ЭМБ-уудын 2023–2025 оны төсвийн төслийг нэгтгэн ЭМЯ, ЭМДЕГ-т хүргүүлсэн мэдээллийг шаардсан боловч хариуцсан мэргэжилтэн ажлаас гарсан, мэдээлэл олдохгүй гэсэн үндэслэлээр шаардлагатай мэдээллийг ирүүлээгүй. Үүний улмаас анхан шатны ЭМБ-уудаас ирүүлсэн орлогын төлөвлөлтийн талаарх судалгаа мэдээллийг тулган баталгаажуулах, төсөв бодитой төлөвлөгдсөн эсэхийг үнэлэх боломжгүй байлаа.

Энэ нь ЭМГ-ын төрийн албаны тасралтгүй ажиллагааг хангах, төсөв нэгтгэх болон мэдээлэл архивлах тогтолцоо сул байгааг харуулж байна.

Иймд аймгийн ЭМГ нь төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтний сул орон тоог яаралтай нөхөж, анхан шатны ЭМБ-уудаас ирүүлж буй төсвийн төсөлд орлого, зардлыг арга хэмжээ тус бүрээр төлөвлөсөн эсэхэд хяналт тавьж, баталгаажуулсан хэлбэрээр хүлээн авах зохион байгуулалтыг сайжруулан, төсвийн төслийн үнэн, зөв байдлыг ханган ажиллах шаардлагатай байна.

График №-14: ЭМБ-уудын орлогын төсвийн төсөвлөлт /Сая.төг/




Аудитын явцад авсан судалгаагаар ЭМЯ-наас ЭМБ-уудын төсвийн төслийг 2023 онд 2,765.0 сая төгрөг, 2024 онд 2,554.4 сая төгрөг, 2025 онд 2,738.7 сая төгрөгөөр тус тус бууруулж баталсан үзүүлэлттэй байна. ЭМЯ болон ЭМДЕГ-аас 2023–2025 оны төсвийн төслийг их хэмжээгээр бууруулан баталсан нь анхан шатны байгууллагууд орлогыг өндөр төлөвлөх хандлагатай

байсныг илтгэж байна.

Тусламж үйлчилгээний санхүүжилтийн орлогын гүйцэтгэл:

График №-15: Анхан шатны ЭМБ-уудын орлогын гүйцэтгэл.




Анхан шатны ЭМБ-ууд тусламж үйлчилгээний орлогыг 2022 онд 3,638.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 3,255.0 сая төгрөгийг төвлөрүүлж 89.4 хувиар, 2023 онд 2,411.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,661.3 сая төгрөгийг төвлөрүүлж 68.9 хувиар, 2024 онд 2,520.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,186.8 сая төгрөгийг төвлөрүүлж 86.7 хувиар биелүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө 2022 онд

383.9 сая төгрөгөөр буюу 10.6 хувиар, 2023 онд 750.0 сая төгрөгөөр буюу 31.0 хувиар тасарсан нь тусламж үйлчилгээний орлогын бүрдүүлэлт хангалтгүй байсантай холбоотой, 2024 онд

334.1 сая төгрөгөөр буюу 13.3 хувиар тасарсан нь ЭМДС-аас авах тусламж үйлчилгээний орлогын авлагатай холбоотой байна. *График №-16: Лавлагаа шатны ЭМБ-уудын орлогын гүйцэтгэл*

Лавлагаа шатны ЭМБ-ууд үндсэн болон төлбөртэй, тусламж үйлчилгээний орлогоос 2022 онд 9,250.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 8,275.4 сая төгрөгийг төвлөрүүлж 89.5 хувиар, 2023 онд 7,817.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 7,985.3 сая төгрөгийг төвлөрүүлж 101.0 хувиар, 2024 онд 12,601.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 11,251.6 сая төгрөгийг төвлөрүүлж 89.3 хувиар биелүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө 2022 онд 974.8 сая төгрөгөөр буюу 10.5 хувиар, 2024 онд 1,349.6 сая төгрөгөөр буюу 10.7 хувиар тасарсан нь тусламж үйлчилгээний орлогын бүрдүүлэлт хангалтгүй байгаатай холбоотой байна.



Иймд анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагууд тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний стандартуудыг чанд мөрдүүлэх, өвчтөнд хүртээмжтэй үйлчлэх орчныг сайжруулах, хүчин чадлын зохистой төлөвлөлт хийх, мөн санхүүгийн нөөцийн оновчтой зарцуулалтыг хангах замаар үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах нь зүйтэй.

Эрүүл мэндийн яамнаас 2025 онд лавлагаа шатлалын ЭМБ-уудын өөрийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 3 дахин нэмэгдүүлэн баталсан байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4¹⁴ -д төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу нэмэлтээр үзүүлж нэмэлт орлого бүрдүүлэхээр заасан байна.

Харин тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.3¹⁵ -т өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийг иргэнээс төлбөр авч тусламж, үйлчилгээ үзүүлэхийг хориглосон байна.

Иймд аймгийн лавлагаа шатны /Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг/ эмнэлгүүд хуулийн дагуу иргэн оношийн хамааралтай бүлгээс шалтгаалан төлж буй хамтын төлбөр¹⁶ болон төлбөртэй нэмэлтээр үзүүлэх тусламжийн үйлчилгээний орлогыг төлөвлөн бүрдүүлж байна.

Лавлагаа шатны 2 эмнэлгүүд төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 2022-2024 онд 796.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,084.0 сая төгрөгөөр буюу 136.2 хувиар давж биелсэн байна.

Хүснэгт №-10 Лавлагаа шатны эмнэлгийн үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл

¹⁴ Энэ хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу нэмэлтээр үзүүлж болох бөгөөд нэмэлт үйлчилгээний төлбөрийг иргэнээс төлүүлэхтэй холбогдох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

¹⁵ Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв энэ хууль болон Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд зааснаас бусад тохиолдолд иргэнээс төлбөр авч тусламж, үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

¹⁶ Хамтын төлбөр гэж “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээтэй эрүүл мэндийн байгууллагаас тусламж үйлчилгээний зардлыг 30 хүртэлх хувийг даатгуулагч өөрөө хариуцан төлөх, үлдсэн төлбөрийг ЭМД-ын сангаас хариуцах”-ыг хэлнэ.

№	Байгууллагын нэр	2022 он			2023 он			2024 он		
		Төл	Гүй	Хувь	Төл	Гүй	Хувь	Төл	Гүй	Хувь
1	УАУНЭ	19.0	22.8	120.1 %	24.0	39.8	165.7 %	42.0	45.5	108.1%
2	Нэгдсэн эмнэлэг	132.8	312.2	235.1 %	309.0	279.7	90.5%	269.1	384.0	142.7%
Нийт		151.8	335.0	220.7 %	333.0	319.4	95.9%	311.1	429.5	138.0%

Эх сурвалж : Аймгийн ЭМД-н хэлтсийн нэхэмжлэлийн хяналтын тайлан


Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн үндсэн үйл ажиллагааны орлого 2022 онд 120.1 хувиар, 2023 онд 165.7 хувиар, 2024 онд 108.1 хувиар тус давж биелсэн бөгөөд тус орлого нь зөвхөн хамтын төлбөрийн орлогоос бүрдсэн байна.

Орлогыг зөвхөн хамтын төлбөрийн орлогоос бүрдүүлсэн нь төлбөртэй үйлчилгээний орлогыг төлөвлөөгүй, нэмэлт үйлчилгээнээс олсон орлогыг төсөвт тайлагнаагүйтэй холбоотой байна.

Тухайлбал тус байгууллага 2022-2025 онд нэмэлт тусламж үйлчилгээнээс олсон /төлбөртэй өрөө/ 15.8 сая төгрөгийн орлогыг төсвийн дансаар дамжуулалгүй, бэлнээр авч 15.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрсэн.

Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5¹⁷, Сангийн сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49,А/118 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчит Эрүүл мэндийн байгууллагаас төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт тусламж, үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах” журмын 2 дугаар зүйлийн 2.1¹⁸, 2.4¹⁹ дэх заалтыг зөрчсөн тул нярав дээр бэлнээр байсан 0.5 сая төгрөгийг төсвийн дансанд тушаалгаж, цаашид тус орлогыг төсвийн дансаар авч зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлээ.

График №-17: Нэгдсэн эмнэлгийн өөрийн орлогын төрөл



Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үндсэн үйл ажиллагааны орлого 2022 онд 235.1 хувиар, 2023 онд 90.5 хувиар, 2024 онд 142.7 хувиар тус давж биелсэн бөгөөд тус орлогыг хамтын төлбөрөөс 362.7 сая, иргэнд үзүүлж буй төлбөртэй тусламж үйлчилгээний орлогоос 236.0 сая, нэмэлт үйлчилгээний орлогоос 377.2 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Нэмэлт төлбөртэй үйлчилгээний орлогын бүрдүүлэлтийг авч үзэхэд төлбөртэй өрөөний орлогоос 2022 онд 72.0 мянга, 2023 онд 65.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 2024 онд огт орлого төвлөрүүлээгүй байна. Тус байгууллага

нь бусад эмнэлгүүдтэй харьцуулахад илүү олон үйлчлүүлэгчтэй, үйлчилгээний ачаалал өндөр байдгийг харгалзан төлбөртэй өрөө ажиллуулж, нэмэлт орлого олох боломжийг судлан анхаарч ажиллах нь зүйтэй байна.

2025 он ЭМЯ-аас лавлагаа шатлалын 2 ЭМБ-ын төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг нь өмнөх жилээс нийт 1,044.6 сая төгрөгөөр буюу 3 дахин нэмэгдүүлж баталсан байна.

¹⁷ Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлж, олсон орлогыг эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, засвар, үйлчилгээ хийхэд зарцуулах бөгөөд уг орлогыг зарцуулах үлгэрчилсэн журмыг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

¹⁸ Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь төлбөртэй тусламж үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлогыг тухай үйлчилгээг үзүүлэхэд оролцсон эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, засвар үйлчилгээ хийхтэй холбоотой зардалд зарцуулна.

¹⁹ Үйлчлүүлэгчийг байгууллагын кассаар эсвэл цахимаар төлбөр төлөх бүхий л боломжоор хангаж төлбөрийг төрийн сан дахь төсвийн үндсэн үйл ажиллагааны дансанд дансанд төвлөрүүлнэ.

Хүснэгт №-11: Лавлагаа шатлалын эмнэлгийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний өсөлт

№	Байгууллагын нэр	2024 он	2025 он	Зөрүү
1	Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг	42.0	432.4	390.4
2	Нэгдсэн эмнэлэг	269.1	923.3	654.2
Нийт		311.1	1,355.7	1,044.6

Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн орлого 390.4 сая төгрөгөөр буюу 9.3 дахин, Нэгдсэн эмнэлгийн орлого 654.2 сая төгрөгөөр буюу 2.4 дахин нэмэгдсэн байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолоор ЭМБ-аас үзүүлэх тусламж, үйлчилгээний “Архаг” болон “Төлөвлөгөөт” тусламж үйлчилгээнд хамаарах өвчин эмгэгтэй хүнд үйлчилж нэхэмжлэх санхүүжилтийг 80-100 хувиар хязгаарлаж, хэтэрсэн тохиолдолд иргэнээс төлбөрийг нь авч үйлчилгээ үзүүлэхээр зохицуулсантай холбоотой байна.

2025 оны 11 дүгээр сарын байдлаар Нэгдсэн эмнэлэг 820.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 292.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 527.5 сая төгрөгөөр буюу 64.4 хувиар, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг 394.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 51.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 342.7 сая төгрөгөөр буюу 86.9 хувиар тус тасарсан үзүүлэлттэй байна.

Иймд лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагууд одоо мөрдөж буй тусламж, үйлчилгээний бүтэц, ачаалал, иргэдийн эрэлт хэрэгцээ болон байгууллагын хүчин чадлыг үндэслэн төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний төрөл, хүртээмжийг өргөжүүлэн нэмэгдүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн хасагдал 2022-2024 онуудад нэмэгдэж, нийт санхүүжилтийн хасагдал 2,609.6 сая төгрөгт хүрсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5-д эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7- д заасан журамд тусгагдсан чанарын шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгохоор заасан байна.

Эрүүл мэндийн салбарын үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор эрүүл мэндийн даатгалын байгууллага нь тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгүүд, тэдгээрийн төлбөрийн хэмжээг тогтоож, эмнэлгүүдийн үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг хянаж, санхүүжүүлж байна.


Дундговь аймагт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй орон нутгийн өмчит анхан болон лавлагаа шатны ЭМБ-ууд 2022 онд 153,008 иргэн даатгуулагчид үйлчилгээ үзүүлж 14,045.3 сая төгрөгийн, 2023 онд 116,514 иргэн даатгуулагчид үйлчилгээ үзүүлж 15,977.1 сая төгрөгийн, 2024 онд 139,077 иргэн даатгуулагчид үйлчилгээ үзүүлж 22,998.5 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №-12: Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээ үзүүлж санхүүжилт авсан байдал

д/д	Эрүүл мэндийн байгууллагын нэр	2022 он		2023 он		2024 он	
		Иргэний тоо	Олгосон санхүүжилт	Иргэний тоо	Олгосон санхүүжилт	Иргэний тоо	Олгосон санхүүжилт
1	Лавлагаа шат ЭМБ	97,734	6,686.8	98,415	7,733.5	105,748	10,238.0
2	Сумын ЭМТ	45,264	6,681.4	15,886	7,529.3	26,891	11,782.4
3	Өрхийн ЭМТ	10,090	677.1	2,213	714.3	6,438	978.0
	Нийт	153,088	14,045.3	116,514	15,977.1	139,077	22,998.5

Эрүүл мэндийн байгууллагууд 2022-2024 онд нийт 413,220 тусламж үйлчилгээ үзүүлж 55,373.8 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс 9,892 тусламж үйлчилгээний 2,609.6 сая төгрөгийн санхүүжилт цахим болон эмч, байцаагчийн хяналтаар хасагдаж, 403,328 тусламж үйлчилгээний 52,773.4 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Хяналтаар хасагдсан 9,892 тусламж үйлчилгээ нь нийт тусламж үйлчилгээний 2.4 хувийг, 2,609.6 сая төгрөг нь нийт нэхэмжилсэн санхүүжилтийн 4.7 хувийг тус тус эзэлж байна. /Дэлгэрэнгүйг хавсралт № 9 дүгээр хүснэгтээс харна уу/


График №-18: Санхүүжилтийн хасагдлын мэдээ



Анхан шатны ЭМБ-уудын санхүүжилтийн хасагдал 2023 онд 186.9 сая төгрөг болж өмнөх оноос 135.4 сая төгрөгөөр буурч, 2024 онд 265.0 сая төгрөг болж 78.1 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Харин лавлагаа шатлалт ЭМБ-уудын хувьд 2023 онд 618.9 сая төгрөг болж өмнөх оноос 67.3 сая төгрөг, 2024 онд 664.0 сая төгрөг болж өмнөх оноос 46.0 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт № 10 дугаар хүснэгтээс харна уу/

Эх сурвалж : Аймгийн ЭМД-н хэлтсийн нэхэмжлэлийн хяналтын тайлан

График №-19: Санхүүжилтийн хасагдлын төрөл



Аймгийн ЭМДХ нь олон улсын эмнэл зүйн удирдамжид суурилсан чанарын шалгуурыг цахим хяналт, эмчийн хяналт, эх олонлогийн гэсэн 3 төрлөөр хослуулан худалдан авсан тусламж үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж байна. Хасагдлыг төрлөөр авч үзвэл эмч байцаагчийн хяналтаар 1,099.7 сая төгрөг буюу 42.1 хувь, цахим хяналтаар 1,013.1 сая төгрөг буюу 38.8 хувь, Эх олонлогийн хасалтаар 496.7 сая төгрөг буюу 19.0 хувь нь тус тус хасагдсан байна.

Аймгийн ЭМДХ-ээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын шаардлага хангаагүй, нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан зардлын шалтгаан, алдаа, зөрчлийг олгох санхүүжилтийн дүн, зөвлөмжийн хамт эрүүл мэндийн байгууллагууд нэхэмжлэлийн хяналтыг дууссан тухай бүр албан бичгээр хүргүүлж байна. ЭМБ-уудын хариуцсан ажилтан хасагдлын шалтгааныг тусламж үйлчилгээний төрөл, илгээсэн эмч тус бүрээр гаргаж алдаа зөрчлийг давтан гаргуулахгүй байх асуудлаар заавар зөвлөгөө өгч байгаа боловч хасагдал буурахгүй байна.

Гүйцэтгэлийн санхүүжилтийн хасагдлын дүн өссөн нь эмч ажилтны ЭМДҮЗ-ийн тогтоолоор баталсан журам зааврын мэдлэг дутмаг байдлаас ЭМДС-ын эмнэл зүйн шалгуур хангаагүй, анхан шатны баримт ирүүлээгүй, бодит цагийн горим хэрэгжүүлээгүй, оношийн код ахиулах зэрэг бусад зөрчилтэй нэхэмжлэл ирүүлдэгтэй холбоотой байна.

Хасагдлын шалтгааны дэлгэрэнгүйг хавсралт № 11 дүгээр хүснэгтээс харна уу.

Иймд анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих нэхэмжлэлийг илгээх ажлыг сайжруулах асуудлаар судалгаа гаргаж, шалтгаан нөхцөл байдлыг тодорхойлсны үндсэн дээр тэдгээрт чиглэсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулах шаардлагатай байна.

ЭМДС-аас хэрэгжүүлж байгаа нэхэмжлэлийн хяналт нь эмч мэргэжилтнүүдийн нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл явцыг дэмжих, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой байна.

Гэвч аудитын явцад ЭМБ-уудаас үзүүлж буй тусламж, үйлчилгээ, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд дараах хүндрэл бэрхшээлүүд тулгарч байна.

Үүнд:

- Анхан болон лавлагаа шатны ЭМБ-ууд тус бүр 4 программ ашиглаж иргэнд үзүүлсэн тусламж үйлчилгээний нэхэмжлэлийг үүсгэж байгаа нь эмнэлгийн эмч ажилчдын ачааллыг үүсгэдэг.
- Програмын гацалтаас шалтгаалж дахин шивж нэхэмжилсэн тусламж үйлчилгээ давхардаж хасагддаг.
- ЭМДҮЗ-ийн тогтоол, ЭМДҮЗ-ийн нэхэмжлэлийн хяналтын тогтоол байнга өөрчлөгдөж байдагтай холбоотой програмын хөгжүүлэлт сүүлдэж орсны улмаас програмын хасагдал их үүсдэг.
- Нэг иргэнд үзүүлсэн яаралтай тусламж, үзлэг оношилгоо, шинжилгээ, хэвтэн эмчлүүлж байгаа тусламж, үйлчилгээний санхүүжилтээс зөвхөн хэвтүүлэн эмчилсэн үйлчилгээний санхүүжилтийг нэхэмжилж авах боломжтой байдаг.
- Нэхэмжлэхийн шалгуурт заасан бодит цагийн горим нь 24 цаг байгаа нь зарим тусламж, үйлчилгээний хувьд эмч, сувилагчийн ажлын ачаалалтай зохицохгүй байна.
- Баянжаргалан суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж аж ахуй нэгжид ажиллаж байгаа гадаад иргэн түр оршин суугчаар бүртгүүлж ЭМД төлөөгүй байдаг учир зайлиггүй шаардлагаар үзүүлсэн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэхэмжилж авах боломж байдаггүй. Мөн уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаагаар холбоотой хөдөлгөөнт хүн амын тоо өсөж, осол гэмтэл болон бусад тусламж, үйлчилгээний зардлыг өсгөдөг.
- Улсын чанартай авто зам дагуу байршдаг Луус, Хулд сумдад осол аваар их гарч эмч ажилтны ажлын ачааллыг нэмэгдүүлж, зарим тусламж, үйлчилгээний зардлыг нэхэмжилж авч чадахгүй байх нөхцөл байдал бий болдог.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2023 онд хийгдсэн “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдэвт аудитаар гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлсэнтэй холбоотой орон нутагт бодит байдалтай нийцэхгүй байгаа дээрх асуудлаар ҮАГ-аар дамжуулан ЭМДҮЗ-д санал хүргүүлж байсан боловч өөрчлөлт ороогүй байна.

Иргэдэд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээний санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын гэрээгээр хязгаарлагдаж байгаа нь ЭМБ-уудыг санхүүгийн эрсдэлд оруулж, иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бага зардлаар түргэн шуурхай авах боломжийг хааж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолоор ЭМДС-ийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор ЭМБ-аас үзүүлсэн тусламж, үйлчилгээний зарим төрлийг ЭМБ болон ЭМДЕГ хооронд байгуулсан гэрээнд тусгагдсан тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, санхүүжилтийн дүнгээр хязгаарлаж өгсөн байна. Тухайлбал:

- “Төлөвлөгөөт тусламж, үйлчилгээ”-нд амбулаторийн тусламж, зарим өдрийн эмчилгээ тухайлбал диализ, хорт хавдрын хими, туяа, өдрийн мэс засал, сэргээн засах тусламж, хөнгөвчлөх тусламж, төлөвлөгөөт мэс засал, хавдар, сэтгэцийн эмгэгийг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ, зарим цочмогдуу эмгэгийн хэвтүүлэн эмчлэх эмийн эмчилгээг тооцож гэрээнд тусгагдсан тоо хэмжээнээс хэтэрсэн тохиолдлыг ЭМДҮЗ-ийн тогтоолоор баталсан төлбөрийн хэмжээний 80 хувиар тооцон санхүүжүүлэх эсхүл ЭМБ-тай

зөвшилцөн хэлэлцээр хийж тухай жилийн нэхэмжлэлийг зогсоож иргэнээс төлбөрийг авахыг зөвшөөрнө.

- “Архаг тусламж, үйлчилгээ”-нд өдрийн эмчилгээ, архаг өвчин, эмгэгийг хэвтүүлэн эмчлэх эмийн эмчилгээ, архаг сэргээх, зарим төлөвлөгөөт мэс засал, уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ, сувиллаас үзүүлэх тусламж, үйлчилгээг тооцож, санхүүжүүлэхдээ гэрээнд тусгагдсан тоо хэмжээнээс хэтэрсэн **“огт санхүүжүүлэхгүй”** буюу **“иргэнээс төлбөр авч”** тусламж, үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрнө.
- Харин **“Цочмог тусламж, үйлчилгээ”**-нд эх барих, нярай, осол гэмтэл, халдварт өвчин, амь насанд аюулгүй цочмог өвчин, эмгэгийн тусламж, яаралтай мэс засал, түргэн тусламж, яаралтай тусламж зэрэг тухайн өвчин эмгэгийг цаг алдалгүй эмчлэх зорилгоор үзүүлж буй үйлчилгээг хамруулж гэрээнд тусгагдсан тоо хэмжээг хязгаарлахгүйгээр санхүүжүүлэхээр заасан байна.

ЭМДЕГ-аас 2025 онд иргэдэд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, санхүүжилтийг дээрх 3 төрлөөр ангилан эрүүл мэндийн даатгалын гэрээгээр хязгаарласан нь ЭМБ-ууд зарим тусламж, үйлчилгээг иргэдэд бага зардлаар, түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх боломж хязгаарлагдаж байна. Ялангуяа архаг өвчтэй иргэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх боломж багасаж, шаардлагатай бол өөрсдөө төлбөр төлж үйлчилгээ авах, эсхүл хүлээж байгаад санхүүжилт авах боломж бүрдсэн нөхцөлд үйлчилгээ авахаар болсон байна.

График №-20 Санал асуулгын дүнгээс



Аудитын явцад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар сэтгэл ханамжийн судалгааг 401 иргэнээс цахим болон цаасан хэлбэрээр авсан санал асуулгаар **“Улсын эмнэлгүүд 100 хувийн төлбөртэй үйлчилгээ үзүүлбэл та аймгийнхаа улсын эмнэлгээр үйлчлүүлэх үү”** гэсэн асуултад судалгаанд хамрагдсан 401 иргэний 59 хувь нь **“Үйлчлүүлэхгүй”** гэж хариулсан байна. Судалгааны дүнгээс харахад эмнэлгүүдийн төсөвт тавьсан хязгаарлалтын улмаас үйлчилгээний төлбөрийг иргэнээр бүрэн

гаргуулбал аймгийн эмнэлгээр үйлчлүүлэх иргэдийн тоо цөөрч орлого бүрдүүлж чадахгүйд хүрэх магадлалтай байна. Өөрөөр хэлбэл нэгэнт төлбөрөө бүрэн төлбөл бусад эмнэлгээр үйлчлүүлэх сонирхолтой байна гэж дүгнэж болохоор байна.

Мөн аудитаар түүвэрт хамруулсан аймгийн Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, Сайнцагаан, Эрдэнэдалай, Баянжаргалан, Хулд сумдын Эрүүл мэндийн төвүүдийг аудитад санхүүжилтийн гэрээний хязгаарлалттай холбоотой бэрхшээлүүд тулгарч байна. Тухайлбал:



- Уламжлалтын анагаах ухааны нэгдсэн эмнэлэг зөвхөн **“Архаг тусламж үйлчилгээ”** -нд хамаарах уламжлалт анагаах ухааны 4 тусламж үйлчилгээг үзүүлдэг бөгөөд 2024 онд гүйцэтгэлээр сард дунджаар 75.3 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилж авч байсан бол 2025 онд төсвийн хуваарь болон гэрээгээр 39.2 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилж авах болсон нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах боломжгүй байдалд хүргэхээр байна



- Нэгдсэн эмнэлэг дээрх 3 төрлийн тусламж, үйлчилгээнд хамаарах 14 тусламж, үйлчилгээг үзүүлдэг бөгөөд 2024 онд гүйцэтгэлээр сард дунджаар 813.4 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилж авч байсан бол 2025 онд төсвийн хуваарь болон гэрээгээр 599.7 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилж авах болсон нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах боломжгүй байдалд

хүрсэн байна. Тус эмнэлгийн хувьд ЭМДС-аас авах авлага байхгүй учир орлогоо нэмэгдүүлэхгүй бол төсөв улам хүндэрч өр нэмэгдэх эрсдэлтэй байна.



- Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн хувьд мөн адил дээрх 3 төрлийн тусламж, үйлчилгээнд хамаарах өвчин эмгэгийг ЭМБ болон ЭМДЕГ хооронд тухайн жилд байгуулсан гэрээнд тусгагдсан тоо хэмжээ, санхүүжилтийн хүрээнд үзүүлж байна. Иймээс өрх, сумын эрүүл мэндийн төвүүд цалин хөлс, хоол хүнс, эмийн зардлын өр, төлбөр үүсэж эхэлсэн байна. Тухайлбал:

Эрдэнэдалай, Хулд, Баянжаргалан сумдын ЭМТ-үүд 7, 8 сараас эмч ажилчдад илүү цагийн хөлсийг олгож чадахгүйд хүрч биеэр эдлүүлж байна.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд зарим тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, санхүүжилтийг хязгаарласнаар эмнэлгийн орлогын тасалдал, үйлчилгээний хүртээмж буурах, өр төлбөр нэмэгдэх зэрэг санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлүүд бий болж байна.

Мөн ЭМБ үзүүлсэн үйлчилгээний үр дүн, гүйцэтгэлийн чанар, тоо хэмжээ, хүрсэн үр нөлөөнд тулгуурлан санхүүжилтээ авдаг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчим нэг талаараа алдагдах нөхцөл бий болсон байна.

Анхан шатны эмнэлгүүд гэрээгээр авах ёстой урьдчилан сэргийлэх үзлэг, дархлаажуулалт, хяналт, идэвхжүүлэлтийн багц тусламж, үйлчилгээгээ хангалтгүй үзүүлж, 267.3 сая төгрөгийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн орлогыг авч чадаагүй байна.




Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1²⁰-д анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгч өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн орлогын нэг эх үүсвэр нь нэг иргэнээр тооцон олгож байгаа санхүүжилтээс бүрдэхээр заасан байна.

Нэг иргэнээр тооцсон санхүүжилт нь анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд ЭМДҮЗ-ийн тогтоолоор батлагдсан хүн амын эрсдэлийн бүлгийн коэффициент буюу тухайн эмнэлэгт хамаарах багийн иргэдийн тоог нэг иргэнд ногдох зардлын хэмжээгээр тооцон олгож байгаа санхүүжилт юм.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд 2022 онд **4,193.1** сая, 2023 онд **6,188.8** сая, 2024 онд **8,961.4** сая нийт 19,343.3 сая төгрөгийн нэг иргэнээр тооцсон санхүүжилт авсан байна.

Графикаас харахад нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн гүйцэтгэл 2024 онд 2022 оноос 4,768.3 сая төгрөг буюу 46.8 хувиар тогтвортой өссөн үзүүлэлтэй байна. Энэ нь санхүүжилтийн бодлогын өөрчлөлт, үйлчилгээний бодит гүйцэтгэл сайжирсан, хүн амын хяналт, хамрагдалт сайжирсан зэрэгтэй холбоотой байна.

График №-21: Нэг иргэнээр тооцсон санхүүжилт, гүйцэтгэл



ЭМДҮЗ-ийн 2024 оны 05 дугаар тогтоолоор нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн орлогын 80 хувийг шалгуургүйгээр олгож, 20 хувийг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл буюу гэрээний гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн хангасан хувиар тооцож олгохоор болсон байна. Өмнөх жилүүдэд ЭМБ болон ЭМДЕГ хооронд байгуулсан гэрээнд энэ талаар заалт тусгагдсан боловч ЭМДЕГ-аас үнэлгээ хийлгүй санхүүжилтийг бүрэн олгож байсан байна.

ЭМДЕГ-аас өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн гэрээний хавсралтад заасан 7 шалгуур үзүүлэлтээр хийсэн цахим хяналтын үнэлгээгээр 2024 онд 194.5 сая, 2025 оны эхний хагас жилд 72.8 сая төгрөгийн санхүүжилтийг хассан байна.

²⁰ 17.1.1.энэ хуулийн 6.2-т заасан тусламж, үйлчилгээний жагсаалтыг нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар;

Хүснэгт №-13: ЭМБ-уудын үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд суурилан үнэлгээ хийж нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 20 хувийн олголтыг тооцсон мэдээлэл

№	ЭМТөвийн нэр	2024 он				2025 оны эхний хагас жил				Нийт хасагдсан санхүүжилт
		Үнэлгээний хувь	Төлөвлөгөө	Олгох	Зөрүү	Үнэлгээний хувь	Төлөвлөгөө	Олгохоор тооцсон	Зөрүү	
1	Адаацаг	78.2	27.5	21.5	6.0	85.0	14.0	11.9	2.1	8.1
2	Баянжаргалан	60.0	12.9	7.7	5.2	53.0	6.7	3.5	3.1	8.3
3	Говь-Угтаал	58.1	14.3	8.3	6.0	72.0	7.4	5.3	2.1	8.1
4	Гурвансайхан	46.8	20.7	9.7	11.0	68.0	10.7	7.3	3.4	14.5
5	Дэлгэрхангай	47.3	22.4	10.6	11.8	37.0	11.8	4.3	7.4	19.2
6	Дэлгэрцогт	51.7	15.5	8.0	7.5	58.0	8.1	4.7	3.4	10.9
7	Дэрэн	40.7	21.5	8.8	12.8	74.0	11.4	8.4	3.0	15.7
8	Луус	52.4	18.1	9.5	8.6	75.0	9.7	7.3	2.4	11.1
9	Өлзийт	34.1	22.0	7.5	14.5	37.0	11.4	4.2	7.2	21.7
10	Өндөршил	34.3	14.1	4.9	9.3	52.0	7.6	4.0	3.7	13.0
11	Сайнцагаан	47.3	51.9	24.6	27.4	80.0	28.1	22.5	5.6	33.0
12	Сайхан-Овоо	50.8	20.9	10.6	10.3	72.0	10.8	7.8	3.0	13.3
13	Хулд	49.7	22.6	11.2	11.4	66.0	11.6	7.7	3.9	15.3
14	Цагаандэлгэр	28.6	9.9	2.8	7.1	34.0	5.3	1.8	3.5	10.6
15	Эрдэнэдалай	58.9	58.9	34.7	24.23	81.0	30.5	24.7	5.8	30.0
16	Боржигон мандал	69.7	52.5	36.6	15.9	-	9.1		9.1	25.1
17	Өлзийт мандал	92.2	70.0	64.5	5.5	93.0	57.0	53.0	4.0	9.5
Нийт дүн			476.1	281.6	194.5		251.3	178.5	72.8	267.3

Эх сурвалж : Аймгийн ЭМД-н хэлтсээс цахимаар ирүүлсэн үнэлгээний мэдээлэл

Дээрх хүснэгтээс харахад Өлзийт мандал ЭМТ 92.2-93.0 хувь, Адаацаг сумын ЭМТ 78.2-85.0 хувьтай хамгийн өндөр үнэлэгдсэн байна. Харин 2024 онд Өлзийт, Өндөршил, Цагаандэлгэр сумд хамгийн бага буюу 28.6–34.3 хувь, 2025 онд Дэлгэрхангай Өлзийт, Цагаандэлгэр сумд хамгийн бага буюу 34.0–34.7 хувьтай үнэлэгдсэн байна. Санхүүжилтээ бүрэн авсан байгууллага байхгүй байна.

Энэ нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд тухайн жилд гэрээгээр авах ёстой урьдчилан сэргийлэх үзлэг, дархлаажуулалт, хяналт, идэвхжүүлэлтийн багц тусламж үйлчилгээгээ бүрэн үзүүлж чадахгүй байгаатай холбоотой байна.

Мөн хүн амын идэвхгүй байдал, эмч, сувилагчийн хүрэлцээ муу, үйлчилгээний баримтжуулалт дутуу, ЭМД-ын сангаас авч байгаа санхүүжилт нь тухай байгууллагын зардлыг бүрэн санхүүжүүлж байсан зэргээс шалтгаалж төсөв захирагч нар 20 хувийн санхүүжилтийг бүрэн авах тал дээр идэвхтэй ажиллахгүй байна гэж дүгнэхээр байна.

Иймд ЭМГ-аас анхан шатны эрүүл мэндийн төвүүдийг тухайн жилд гэрээгээр авах ёстой урьдчилан сэргийлэх үзлэг, дархлаажуулалт, хяналт, идэвхжүүлэлтийн багц тусламж үйлчилгээгээ бүрэн үзүүлж, гэрээний биелэлтийг бүрэн хангаж, нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн орлогын 20 хувийг бүрэн авах талаар нэгдсэн арга зүйгээр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

3.2 Аймгийн Нэгдсэн эмнэлэг тусламж үйлчилгээний орлого бүрдүүлэлтийн хангалтгүй байдлаас шалтгаалан алдагдалтай ажиллаж, эх үүсвэр нь тодорхойгүй 2,559.7 сая төгрөгийн өр үүссэн байна.

Анхан болон лавлагаа шатны ЭМБ 2025 оны 9 сарын байдлаар 2,559.7 сая төгрөгийн өр төлбөр, 962.0 сая төгрөгийн авлагатай байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №12 дүгээр хүснэгтээс харна уу./

Өр төлбөр : ЭМБ-уудын нийт өр төлбөр 2025 оны 9 сарын байдлаар 2,559.7 сая төгрөг болж 2021 оноос 1,786.1 сая төгрөгөөр буюу 3.3 дахин өссөн үзүүлэлттэй байна.





График №-23: ЭМБ-ын өр авлагын эзлэх хувь



холбоотой байна.

График №-22: ЭМБ-уудын өр төлбөрийн судалгаа

Өр төлбөрийн 86.7 –288.9 сая төгрөг буюу 6.6–23.4 хувийг анхан шатны ЭМБ, дийлэнх болох 334.6 – 2,385.8 сая төгрөг буюу 76.6 – 93.4 хувийг лавлагаа шатны ЭМБ буюу аймгийн Нэгдсэн эмнэлгийн өр, төлбөр эзэлж байгаа бөгөөд нийт өр, төлбөрийн өсөлтөд нөлөөлсөн байна. Харин аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг 2021 оноос бусад хугацаанд өр төлбөргүй ажилласан байна.

Өр төлбөрийг агуулгаар нь авч үзвэл дийлэнх буюу 58.7 хувь нь эм, эмнэлгийн хэрэгсэл, 20.6 хувь нь цалин хөлс, 1.0 – 13.6 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, бусад зардлын өр, төлбөр байна. Тайлант онуудад өр үүссэн шалтгаан нь анхан шатны ЭМБ-уудын хувьд ЭМДС-аас иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийг нэхэмжилсэн сард нь багтааж олгодоггүйтэй




График №-24: Өр, төлбөрийн агуулга /Хувиар/


График №-25: ЭМБ-ын өр авлагын эзлэх хувь

Тухайлбал: ЭМБ-уудын авлага 2021, 2024 онд өндөр буюу 1,854.0–1,952.2 сая төгрөг болж өссөн бөгөөд авлагын дийлэнх буюу 93.1 хувийг ЭМДС-аас авах тусламж, үйлчилгээний санхүүжилтийн авлага эзэлж байна.

Анхан шатны ЭМБ-ууд ЭМДС-аас авах санхүүжилтийн авлага дараа ондоо авч өр, төлбөрөө барагдуулж байна. Энэ нь байгууллагын төлбөрийн чадвар болон санхүүгийн урсгалд хүндрэл үүсгэж, улмаар Төсвийн тухай хуульд заасан “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” зарчим зөрчигдөх нөхцөлийг бий болгож байна.




График №-26: Нэгдсэн эмнэлгийн өр, авлага харьцуулалт



эрсдэлийн түвшин нэмэгдсэнийг илтгэнэ. Авлага үүсээгүй нөхцөлд ийм хэмжээний өр хуримтлагдсан нь дотоод хяналт, төсвийн зохион байгуулалт, зарцуулалтын сахилга батад анхаарах шаардлагатайг харуулж байна.

График №-27: Нэгдсэн эмнэлгийн зардлын бүтэц



хүний нөөцийн оролцоо ихтэй, мөн эмнэлгийн тусламж, үйлчилгээний үндсэн хэрэглээ болох эм, хэрэгслийн үнийн өсөлттэй холбоотой.

Нэгдсэн эмнэлгийн өр төлбөрийн гол шалтгаан нь байгууллагын удирдлагын менежмент, орлогын төлөвлөлт, цалин болон эмийн зардлын хяналт, худалдан авалтын зохистой байдал, ЭМДС-ийн санхүүжилтийн хасагдал зэрэг санхүүгийн удирдлагын олон хүчин зүйлсийн хангалтгүй дараах байдлаас шалтгаалж байна.

Үүнд:

- Орлогын төлөвлөлтийн биелэлт хангалтгүй байгууллагын тусламж, үйлчилгээний орлогын төлөвлөгөө 2022 онд 828.0 сая төгрөг, 2024 онд 1,260.5 сая төгрөгөөр тасарсан бөгөөд төлөвлөсөн орлогоо бүрдүүлж чадаагүй, мөн ЭМД-ын сангаас нэхэмжилсэн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн хасагдал 2022–2024 онд нийт 1,686.0 сая төгрөгт хүрсэн.
- Ажилчдын илүү цагийн хяналт хангалтгүй, ажлын бус цагаар ажилласан эмч, ажилчдын цагийг дэвтрээр бүртгэдэг боловч бодитоор ажилласан цагийг нягтлан шалгах, баталгаажуулах, хяналтын механизмыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг 2025 оны 10 сарын байдлаар 2,473.0 сая төгрөгийн өр төлбөртэй боловч ЭМДС-аас авах санхүүжилтийн авлагагүй байна. Өр, төлбөрийг агуулгаар нь авч үзвэл эм, эмнэлгийн хэрэгслийн өр төлбөр 1,381.2 сая төгрөг буюу 55.9 хувь, ХХОАТ-ын өр төлбөр 718.0 сая төгрөг буюу 29.0 хувь, бусад өр төлбөр 6.9 хувийг тус тус эзэлж байна.

Тус байгууллагын өр, төлбөр нь 2023 оноос үүсэж эхэлсэн бөгөөд төлбөрийг барагдуулах боломжгүй болсон нь байгууллагын санхүүгийн урсгалын тэнцвэр алдагдаж, байгууллагын санхүүгийн

Үзүүлэлт	Өр, төлбөр дэлгэрэнгүй /Сая төгрөгөөр/				
	ХХОАТ	НДШ	Эм эмнэлгийн хэрэгсэл	Шатахуун	Бусад
Мөнгөн дүн	718.0	190.1	1,381.2	12.8	170.9
Эзлэх хувь	29.0	7.7	55.9	0.5	6.9

Хүснэгт №-14: Нэгдсэн эмнэлгийн өр, төлбөрийн мэдээлэл

Графикаас харахад нийт зардлын дийлэнх буюу цалин, НДШ-ийн зардал 2022 онд 63.1 хувь, 2023 онд 72.3 хувь, 2024 онд 71.6 хувийг, Эм эмнэлгийн хэрэгслийн зардал 2022 онд 24.7 хувь, 2023 онд 17.9 хувь, 2024 онд 15.3 хувийг тус эзэлж байна. Харин бусад зардал хамгийн бага буюу 9.8-13.0 хувийг эзэлж байна.

Цалин, НДШ болон эм, эмнэлгийн хэрэгслийн зардал өндөр хувь эзэлж буй нь эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа,

- Илүү цагийн нэмэгдлийг буруу тооцож, 2024 оноос өмнө ажилтны илүү цагийн нэмэгдлийг хөдөлмөрийн дундаж цалин хөлсийг “хоёр” дахин нэмэгдүүлэн олгож цалингийн зардлыг сард 28.0 сая төгрөгөөр өсгөсөн.
- Ердийн цагийн бүртгэлд хяналт сул, цагийн балансын бүртгэлд хоцорсон, тасалсан, тасалдалтай ажилласан цагийн мэдээлэл огт тусгагдаагүй бөгөөд ажилчдын ажлын цагийн ашиглалтад тавих хяналт сул байна.
- Эмийн тендерийн нийлүүлэлтийн тасалдал, хугацаанд нь барагдуулаагүй өрийн улмаас тендерт шалгарсан нийлүүлэгч эмийн нийлүүлэлтийг зогсоосонтой холбоотой ерөнхий гэрээний дагуу өндөр үнээр эм худалдан авч байгаа нь зардлыг нэмэгдүүлж байна.
- Байгууллагын удирдлага удаа дараа солигдон удирдлагын зохион байгуулалтын менежмент алдагдаж, санхүү, аж ахуйн удирдлага суларч, дотоод хяналтын хангалтгүй байдал бий болж ажилтнуудын ажлын сахилга хариуцлага сулрах нөхцөлийг бий болгосон.

2024 онд ЭМЯ-наас хэрэгжүүлсэн АХБ-ны эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх төслийн ажилтантай хамтран эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаа доголдож өр, төлбөр үүссэн нөхцөл байдалд үр ашгийн тооцоолол хийсэн байна. Үр ашгийн тооцооллоор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх орчин нөхцөл, эмчийн хангалт сайн байгаа боловч, ажлын цаг ашиглалт, харилцан адилгүй ажлын гүйцэтгэл, ажлын ачааллын тэнцвэргүй байдал, E-health программын ашиглалтын ур чадвар, ЭМДҮЗ-ийн нэхэмжлэлийн шалгуурын хангалт харилцан адилгүй, эмч ажилтны ёс зүй, хандлагыг сайжруулах шаардлагатай байгаа талаар тодорхойлсон байна. Гэвч үр ашгийн тооцооллын хүрээнд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Мөн Эрүүл мэндийн салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэхтэй холбоотой ЭМЯ-наас **Төв, Булган, Өвөрхангай, Дорноговь, Дундговь** аймгийн нэгдсэн эмнэлгүүд өр төлбөр үүсэх өндөр эрсдэлтэй байгааг урьдчилан тодорхойлж, төсвийн зардлыг өөрийн үйл ажиллагааны орлого болон ЭМДС-аас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний орлоготой уялдуулж төлөвлөж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах чиглэл өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дээрх нөхцөл байдал нь байгууллагын удирдлагаас өр авлагыг бууруулах чиглэлээр санаачилгагүй ажиллаж байгааг харуулж байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн тогтворгүй байдал нэмэгдэх, тусламж үйлчилгээний чанар, хүртээмж буурах эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.

2023, 2024 онд ЭМГ-аас 2025 онд аймгийн ЗДТГ-аас тус байгууллагын дотоод үйл ажиллагаа, тусламж үйлчилгээ, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийсэн боловч нөхцөл шалтгааныг тодорхойлж цаашид арга хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх дүгнэлт, зөвлөмжийг баталгаажуулж өгөөгүй байна.

Энэ нь холбогдох албан тушаалтнуудын ажлын хариуцлагагүй байдлаас шалтгаалж дээд шатны байгууллагаас удирдлага арга зүйгээр хангагдаж, үүссэн өр төлбөр нэмэгдэх эрсдэлийг эрт бууруулах боломж хязгаарлагдсан байна.

Иймд дээрх нөхцөл байдлыг удирдлагын түвшинд бодитойгоор дүгнэн шинжилж, тусламж, үйлчилгээний орлогыг нэмэгдүүлэх, үр ашиггүй зардлыг бууруулах, төлөгдөх эх үүсвэр нь тодорхойгүй байгаа өр төлбөрийг шат дараатайгаар барагдуулах, цогц шийдвэрийг яаралтай гарган хэрэгжүүлэх шаардлагатай байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Аймгийн Эрүүл мэндийн салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг батлаагүй байна.
2. Улсын хэмжээнд хэрэгжиж байгаа хөтөлбөрүүд болон аймгийн ИТХ-аас “Эрүүл Дундговь” дэд хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлэхээр баталсан байна.
3. Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээний дүнгээр аймгийн эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн үнэлгээ сүүлийн жилүүдэд буурч хангалтгүй үнэлэгдсэн байна.
4. Нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулаагүй байна.
5. Нэгдсэн эмнэлгийн даргыг Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу томилоогүй байна.
6. Нийгмийн бодлогын хэлтэс нь хууль, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байна.
7. Таван сумын Эрүүл мэндийн төвийн даргын томилгоо зөрчилтэй байна.
8. Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд 13.3 сая төгрөгийн хохирол учирсан байна.
9. Аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт сүүлийн жилүүдэд тогтвортой байж, сул орон тоо 2025 оны 10 дугаар сарын байдлаар 70 болж буурсан үзүүлэлттэй байна.
10. Эрүүл мэндийн байгууллагуудын 2022-2024 онд нэхэмжилсэн санхүүжилтийн хасагдал 2,609.6 сая төгрөг буюу санхүүжилтийн хасагдал буураагүй байна.
11. Иргэдэд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээний санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын гэрээгээр хязгаарлагдаж байгаа нь ЭМБ-уудыг санхүүгийн эрсдэлд оруулж, зарим иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бага зардлаар түргэн шуурхай авах боломжийг хааж байна.
12. Анхан шатны эмнэлгүүд гэрээгээр авах ёстой урьдчилан сэргийлэх үзлэг, дархлаажуулалт, хяналт, идэвхжүүлэлтийн багц тусламж, үйлчилгээгээ хангалтгүй үзүүлж, 267.3 сая төгрөгийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн орлогыг авч чадаагүй байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

- **Аймгийн Засаг даргад**

1. Аймгийн нэгдсэн эмнэлгийн өр төлбөрийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, өр үүссэн шалтгааныг нарийвчлан тодорхойлж, санхүүгийн сахилга бат, төлбөрийн чадварыг сайжруулахад чиглэсэн нэгдсэн бодлого, шийдвэрийг шуурхай гарган хэрэгжүүлэх;
2. Нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийг холбогдох хууль, журмын дагуу байгуулж, Эрүүл мэндийн тухай хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, эмнэлгийн даргыг хуулийн дагуу томилуулах;

- **Аймгийн Засаг даргын Тамгын газарт:**

1. Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн салбар хариуцсан мэргэжилтний орон тоог нөхөж, эрүүл мэндийн салбарын байгууллагуудыг арга зүйгээр хангах, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;

- **Эрүүл мэндийн газарт:**

1. Эрүүл мэндийн салбарын стратеги төлөвлөгөөг салбарын болон аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тулгуурлан, орон нутгийн онцлогтой уялдуулж, судалгаа, шинжилгээ, тоон мэдээлэлд үндэслэн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бодитой тодорхойлж, боловсруулан батлуулж хэрэгжүүлэх;
2. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг тооцож, чиглэл, арга зүйгээр ханган хяналт тавьж ажиллах;
3. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 тушаалаар батлагдсан журмын дагуу анхан болон лавлагаа шатны эмнэлгүүдэд хэрэглэгчийн үнэлгээ хийж байгаа эсэхэд хяналт тавьж, дүнг үйл ажиллагаандаа ашиглах талаар чиглэл, арга зүйгээр хангаж ажиллах;
4. Төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтний сул орон тоог яаралтай нөхөж, анхан шатны ЭМБ-уудаас ирүүлж буй төсвийн төсөлд орлого, зардлыг арга хэмжээ тус бүрээр төлөвлөсөн эсэхэд хяналт тавьж, баталгаажуулсан хэлбэрээр хүлээн авах зохион байгуулалтыг сайжруулан, төсвийн төслийн үнэн, зөв байдлыг ханган ажиллах.
5. Анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн нэхэмжлэлийг илгээх ажлыг сайжруулж, шалтгаан нөхцөл байдлыг тодорхойлж, хасагдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцох.
6. Нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн орлогын 20 хувийг бүрэн авах асуудлаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг нэгдсэн арга зүйгээр хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

- **Нэгдсэн эмнэлэгт:**

1. Иргэдийн эрэлт, хэрэгцээ болон байгууллагын хүчин чадлыг үндэслэн төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний төрөл, хүртээмжийг өргөжүүлэн нэмэгдүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах;
2. Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг ил тод, үүрэг хариуцлагыг тодорхой байдлаар шинэчлэн, дотоод хяналтын тогтолцоо, орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, санхүүгийн менежментийг сайжруулах цогц төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг нь хангаж ажиллах;
3. Үүссэн өр, төлбөрийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шалтгааныг нарийвчлан тодорхойлж, санхүүгийн сахилга бат, төлбөрийн чадварыг сайжруулахад чиглэсэн нэгдсэн бодлого, шийдвэрийг шуурхай гарган хэрэгжүүлэх. Мөн өр, төлбөрийг үе шаттайгаар барагдуулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд тухай бүр хяналт тавьж, үр дүнг нь тооцож ажиллах;

- **Сумдын Засаг дарга нарт:**

1. Сумын Эрүүл мэндийн төвийн даргыг холбогдох хууль, журмын дагуу томилж, зөрчлийг арилгах;



Шалгагдагч байгууллагын санал тайлбар



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-213 тоот, 7 дугаар баг,
Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48090 Утас: 7059 2353
Цахим шуудан: info@dundgovi.gov.mn,
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2025.12.16 № 01/1682

танай 2025.12.15 -ны № 01/202

ДУНДГОВЬ АЙМАГТ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Р.МӨНХТОГТОХ ТАНАА

Танай байгууллагаас “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийсэн тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус төсөлд санал тайлбар байхгүй болно.



С.МӨНХЧУЛУУН

4825140821

ЭНД-2025-ТАЙЛ...



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Дундговь аймаг, 48090 Сайнцагаан сум, 7 дугаар баг,
С.Буяннэмэхийн өргөн чөлөө 1-103
Утас: 70593894, Факс: 70593894
Цахим шуудан: em_gazar@dundgovi.gov.mn
Цахим хуудас: du.mohs.mn

2025.12.16 № 01/594

танай 2025.12.15 -ны № 01/203 -т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцсан тусгайлан гаргах саналгүй.

Жич: Төрд учруулсан хохирлыг төлж барагдуулсан, баримтыг хүргүүлсэн болно.



Дундговь аймгийн эрүүл мэндийн газар
Удирдлага
Дарга
Базарваань Алтантөгс
2025-12-16 17:29:04

Хавсралт №-1 Аймгийн 2021-2025 оны жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, эрүүл мэндийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой заалтуудын уялдаа холбоог харуулсан байдал

Баримт бичгийн нэр	Зорилт	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой арга хэмжээний заалтууд	Санхүүжилтийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Аймаг, нийслэл хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлтийг 2019 онд 57.8 байсныг 2025 он гэхэд 69.8 хувьд хүргэнэ.	Орон нутагт шаардлагатай газарт яаралтай тусламжийн цэг байгуулна.	6 заалтын 2 нь санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй	* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт, зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулна.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хэрэглэгчийн үнэлгээний эерэг үзүүлэлтийг 2020 онд 91.5 хувь байсныг 2025 онд 2 хувиар нэмэгдүүлнэ.	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, яаралтай тусламжийн зөөврийн тоног, төхөөрөмжөөр тоноглоно.		* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Нэгдсэн эмнэлгийг компьютер томографик болон корона вируст халдвар/covid-19/-ын оношилгооны PCR шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангана.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөөг анхан шатны эмнэлгүүдэд алсын зайнаас авах цахим харилцааны нөхцөлийг бүрдүүлэн компьютероор хангана.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтын цахим тогтолцоог бүрдүүлж, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлж, эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааны зохицуулалтын эрх зүйн орчныг шийдвэрлэнэ.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлт 2019 онд 57.8 байсныг 2024 он гэхэд 67.4 хувьд хүргэнэ.	Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт, зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулах.	7 заалтын 1 нь санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй	* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Нэгдсэн эмнэлэг болон сумдын эмнэлгүүдийн эхчүүдийн амрах байрны орчин нөхцөлийг сайжруулах			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус

		0-5 насны архаг хоол тэжээлийн дутагдалтай хүүхдийг эрүүлжүүлэх			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
	Хэрэглэгчийн үнэлгээний эерэг үзүүлэлт 2019 онд 91.5 хувь байсныг 2024 онд 93.6 хувьд хүргэнэ.	Нэгдсэн эмнэлгийг компьютер томографик, сумдыг мобайль технологиор хангах		* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Хот хоорондын зам дагуух сумдын болон алслагдсан бүс нутгийн эмнэлгүүдэд яаралтай тусламжийн цэг байгуулах.		* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, яаралтай тусламжийн зөөврийн тоног, төхөөрөмжөөр тоноглох			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөөг анхан шатны эмнэлгүүдэд алсын зайнаас авах цахим харилцааны нөхцөлийг бүрдүүлэн компьютероор хангах.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг 25 хувиар нэмэгдүүлнэ	0-5 насны хүүхдийн хяналтыг сайжруулна	5 заалтын 1 нь санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй	* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Эх барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах		* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг мобайль технологиор хангах			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Нэгдсэн эмнэлгийн мэс заслын стандартад нийцсэн вакум өрөөтэй болгох			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Авто машинд суурилсан нүүдлийн клиниктэй болгох		* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
Эрүүл мэндийн салбарын стратеги төлөвлөгөө 2021-2024 он	Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцооны удирдлагын мэдээллийн тогтолцооны удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлж, бодлогын шийдвэр гаргалтад мэдээ мэдээллийн ашиглалтыг сайжруулах	Хот хоорондын зам дагуух болон алслагдсан бүс нутгийн эмнэлгүүдэд яаралтай тусламжийн цэг байгуулах.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллах			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Хүн амыг халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Эрдэнэдалай, Боржигон мандал, Өлзийт мандал, Гурвансайхан сумын эрүүл мэндийн төвийн автомашины парк шинэчлэлт хийх		* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөөг анхан шатны эмнэлгүүдэд алсын зайнаас авах цахим харилцааны нөхцөлийг бүрдүүлэн компьютероор хангах.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус

		Эрүүл мэндийн мэдээ, мэдээллийн чанар, агуулгыг боловсронгуй болгох			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Эрүүл мэндийн салбарын мэдээллийн цахим мэдээллийн тогтолцоог бий болгох			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
	Эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах орчин нөхцөл, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	Салбарын хэмжээнд эмнэлгүүдийн барилгуудыг стандартын дагуу шинэчлэх, их болон урсгал засвар хийх.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг оношилгоо, эмчилгээний дэвшилтэт тоног төхөөмжөөр хангах.		* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Салбарын хэмжээнд эмнэлгүүдийн дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Салбарын хэмжээнд авто машины парк шинэчлэлтийг тасралтгүй хийх.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Салбарын хэмжээнд багийн эмчийн унааны хангалтыг үе шаттайгаар шийдвэрлэх.		* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг эрүүл мэндийн цахим бүртгэл, зайн оношилгооны тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээ болон стандарттай уялдуулан салбарын хүний нөөцийг хангах бодлогыг хэрэгжүүлэх.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байр болон дотоод гадаадын сургалтаар чадавхжуулах, мэргэшүүлэх		* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
	Мэргэшсэн, чадавхтай, мэргэжлийн хүний нөөцийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шатлал бүрд хангана.	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд параклиникийн тусламжийг өргөжүүлэн нотолгоонд суурилсан тусламж үзүүлэх.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Эх хүүхдийн тусламжийн чанар хүртээмжийг сайжруулах			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Сувилахуй, сэргээн засах, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, нийгмийн эрүүл мэндийн сувилахуй, ахмадын сувилахуйг хөгжүүлэх.		* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх.		* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
		Хүн амд эрүүл мэндийн боловсрол, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны чанар, хүртээмжийг сайжруулах		* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус

	Халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн хамрах хүрээг өргөжүүлж, чанарыг сайжруулах, үр дүнг тооцох			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
	Иргэн, өрх гэр бүл, байгууллага, хамт олонд түшиглэн эрүүл мэндэд ээлтэй орчныг бүрдүүлэх.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын нэгжийн чадавхыг нэмэгдүүлж, хүн амын дунд дархлал тогтцын түвшнийг тодорхойлж идэвхтэй тандалт хийх.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
	Нийгмийн эрүүл мэндийн төв, эрүүл мэндийг дэмжих төв, эрүүл зүйн лаборатори байгуулах.			Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн зайлшгүй шаардлагатай эм, стационарийн эмийн хангамж, хүртээмжийг сайжруулах.		* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус
	Тусламж үйлчилгээний шатлал бүрд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх.		* Шалгуур тодорхойгүй	Хүрэх түвшин тусгагдсан боловч, бодитой бус

Хавсралт №2: Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний нэмэгдсэн, хасагдсан судалгаа

№	Нэмэгдэж, хасагдсан шалтгаан	2021				2022				2023				2024				Нийт
		Нийт	их эмч	Сувилагч	Бусад ажилтан	Нийт	их эмч	Сувилагч	Бусад ажилтан	Нийт	их эмч	Сувилагч	Бусад ажилтан	Нийт	их эмч	Сувилагч	Бусад ажилтан	
1	Нэмэгдсэн	185	33	38	114	145	42	19	84	164	45	35	84	140	37	28	75	634
	Төгсөж ирсэн	33	9	10	14	27	14	6	7	21	7	10	4	21	4	15	2	102
	Шинээр ажилд орсон	110	15	18	77	90	18	10	62	103	23	9	71	99	23	7	69	402
	Шилжиж ирсэн	32	8	9	15	16	6	1	9	15	7	2	6	8	5	1	2	71
	Жирэмсний болон хүүхэд асрах чөлөөнөөс орсон	10	1	1	8	12	4	2	6	25	8	14	3	12	5	5	2	59
2	Хасагдсан	154	44	30	80	181	48	46	87	153	43	25	85	112	26	23	63	600
	Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн	83	28	5	50	105	22	19	64	74	26	8	40	64	18	7	39	326
	Эрүүл мэндийн байгууллага хооронд шилжсэн	6	2	1	3	11	4	3	4	11	3		8	3		2	1	31
	Тэтгэвэрт гарсан	31	1	13	17	21	4	9	8	18	1	7	10	16	2	6	8	86
	Нас барсан	1			1	0				1			1	2		1	1	4
	Группэд орсон	0				0				0				0				0
	Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө авсан	27	12	10	5	43	18	15	10	31	11	6	14	20	6	7	7	121
	Бусад шалтгаанаар /халагдсан/	6	1	1	4	1			1	18	2	4	12	7			7	32

Хавсралт №3: 2021-2024 онд зохион байгуулагдсан дотоод сургалт, хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн

	2021	2022	2023	2024
Ажлын байран дахь сургалт				
Зорилтот түвшин	150	711	1032	1,147
Сургалтын тоо	50	18	34	60
Хамрагдсан албан хаагчийн тоо	291	1,032	1,147	1,167
Хэрэгжилтийн хувь	100%	100%	100%	100%
Мэргэшүүлэх сургалт				
Зорилтот түвшин	15	20	20	36
Сургалтын тоо	34	37	33	36
Хамрагдсан албан хаагчийн тоо	46	54	36	38
Хэрэгжилтийн хувь	100%	100%	100%	100%
Туршлага солилцох арга хэмжээ				
Зорилтот түвшин	30	15	15	47
Сургалтын тоо	-	3	18	3
Хамрагдсан албан хаагчийн тоо	-	87	47	139
Хэрэгжилтийн хувь	-	100%	100%	100%
Бусад сургалт				
Зорилтот түвшин	258	282	342	428
Сургалтын тоо	28	71	117	90
Хамрагдсан албан хаагчийн тоо	357	342	428	1,182
Хэрэгжилтийн хувь	100%	100%	100%	100%

Хавсралт №.4: Сувилагч, тусгай мэргэжилтний төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдсан тоон судалгаа /2021-2025 он/

Он	Эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан	Ариутгагч	Дархлаажуулалт	Яаралтай тусламжийн сувилагч	Хүүхдийн сувилагч	Хөнгөвчлөх эмчилгээний сувилагч	Компьютер томограф/рентген туяа судлал	Нярайн сувилагч	Чих хамар хоолой	Мэдрэл судлал	Мэс засал судлал	Халдвартын сувилахуй	Хавдрын хими эмчилгээний найруулга зүй	Нийгмийн эрүүл мэндийн сувилагч	Сэргээн засах эмчилгээ	Серологи судлал	Бичил амь судлал	Эд судлал	Хавдрын сувилагч	Нийт
2021	1	4	6	1						1	1					1				15
2022			3		2	1				1							1			8
2023	1	3	3			1	1		1			1			2		1			14
2024		1	5	1	1		1	1			2				2			1	1	16
2025													1	1					1	3
Нийт	2	8	17	2	3	2	2	1	1	2	3	1	1	1	4	1	2	1	2	56

Хавсралт №5: Сувилагч, тусгай мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан тоо судалгаа /2021-2025/

Он	Эх баригч сувилагч	Эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан	Гемодиализийн сувилагч	Мэс засал	Нийт
2021			1		1
2023		1			1
2024		2	1	1	4
2025	1				1
Нийт	1	3	2	1	7

Хавсралт №6: Сувилагч, тусгай мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан тоо судалгаа /2021-2025/

Он	Чих хамар хоолой	Дүрс оношилгоо	Гэмтэл согог судлал	Эх барих эмэгтэйчүүд судлал	Арьс судлал	Дотор	Эрчимт эмчилгээ	Яаралтай тусламж	Хүүхэд судлал	Сэтгэц эмгэг судлал	Сэргээн засах	Хавдар	Зоонозын өвчин судлал	Мэс засал	Зүү эмчилгээ судлал	Нийт
2021	1		1			1	1	1	1				1	1		8
2022		1		1				1	1	1	1				1	7
2023					1							1				2
2024		1		1					1							3
2025					1					1			1		1	4
Нийт	1	2	1	2	2	1	1	2	3	2	1	1	2	1	2	24

Хавсралт №7: Төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдсан их эмчийн тоон судалгаа /2021-2025 он/

Он	Сэтгэл засал	Нярай эмч	Эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, үргүйдэл судлал	Орчны эрүүл мэнд	Хоол боловсруулах тогтолцоо	Гавал тархины мэс засал	Цусны эмч	Эмнэлгийн чанар аюулгүй байдал	Хүүхдийн зүрх	Бөөр судлал	Хавдрын хими эмчилгээ	Эрүүл мэндийн удирдлага зохион байгуулалт	Зүрх судлал	Биостатистик, тархвар судлал	Талбарын тархвар судлал	Нийт
2021														1		1
2022			2													2
2023	1			1		1		1							1	5
2024		2			1					1		1				5
2025		1					1		1		1		1			5
Нийт	1	3	2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	18

Хавсралт №8: Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан их эмчийн тоон судалгаа /2021-2025 он/

Он	Хэвлийн хөндийн хэт авиа оношилгоо	Тархины цахилгаан бичлэг	Компьютер томограф	Дурангийн онош зүй	Хавдрын хими эмчилгээний найруулаг зүй	Хэвлийн хөндийн дурангийн мэс засал	Эмэгтэйчүүдийн хэт авиа оношилгоо	Эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал	Яаралтай тусламж	Чих хамар хоолойн мэс засал	Гемодиализийн эмчийн	Нийт
2021										1		1
2022	2											2
2023	2	1	1					1	1			6
2024	3		2	1			1					7
2025	2				1	1	1	1			1	7
Нийт	9	1	3	1	1	1	2	2	1	1	1	23

Хавсралт № 9 Эрүүл мэндийн даатгалын сангаас Дундговь аймгийн анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад олгосон санхүүжилтийн нэгтгэл /сая.төгрөгөөр/

№	Он	Нэхэмжилсэн		Хасагдсан		Тооцсон		Олговол зохих санхүүжилт	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
Лавлагаа шат									
1	2022	99,119	7,229.1	1,385	231.7	0	319.9	97,734.0	6,686.8
2	2023	98,415	8,347.0	377	125.8	908	493.2	97,130.0	7,728.1
3	2024	104,394	10,691.4	578	128.1	1,248	536.8	102,568.0	10,026.6
Нийт дүн		301,928	26,267.6	2,340	485.6	2,156	1,349.9	297,432.0	24,441.4
Анхан шат									
1	2022	59,257	7,828.7	2,729	258.7	0	63.6	56,528	7,506.4
2	2023	18,099	8,252.1	906	109.7	0	77.2	17,193	8,065.2
3	2024	33,936	13,025.4	1,761	245.8	0	19.2	32,175	12,760.4
Нийт дүн		111,292	29,106.2	5,396	614.2	-	160.0	105,896.0	28,332.0
Нийт авсан санхүүжилт									
1	2022	158,376	15,058	4,114	490	-	384	154,262	14,193
2	2023	116,514	16,599	1,283	235	908	570	114,323	15,793
3	2024	138,330	23,717	2,339	374	1,248	556	134,743	22,787
Нийт		413,220	55,373.8	7,736	1,099.7	2,156	1,509.9	403,328.0	52,773.4

Хавсралт № 10 Эрүүл мэндийн тусламж мэндийн даатгалын сангаас Дундговь аймгийн анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад олгосон санхүүжилтийн хасагдлын нэгтгэл /сая.төгрөгөөр/

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	2022 он		2023 он		2024 он		Нийт хасагдал	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
	Анхан шатны ЭМТ-ын төлбөртэй үйлчилгээний санхүүжилт								
1	Адаацаг	122	10.1	15	9.09	25	4.8	162	24.0
2	Баянжаргалан	152	12.3	76	24.00	100	13.6	328	49.9
3	Гурвансайхан	151	14.1	66	21.04	86	35.0	303	70.2
4	Дэлгэрхангай	110	5.1	31	8.07	45	15.3	186	28.5
5	Дэлгэрцогт	3	0.3	17	9.70	175	34.1	195	44.1
6	Дэрэн	79	18.8	14	6.06	39	6.5	132	31.4
7	Луус сум	177	11.3	150	7.81	329	22.7	656	41.8
8	Сайнцагаан	722	63.2	71	2.40	84	5.8	877	71.4
9	Сайхан-Овоо	13	2.5	8	3.45	5	0.9	26	6.9
10	Хулд	172	25.2	28	5.58	55	11.9	255	42.7
11	Цагаандэлгэр	63	13.1	41	5.94	194	36.5	298	55.5
12	Өлзийт	147	25.9	47	21.61	45	13.7	239	61.3
13	Өндөршил	207	27.5	75	25.35	113	17.4	395	70.2
14	Говь-Угтаал	95	40.6	79	8.34	76	6.0	250	55.0
15	Эрдэнэдалай	209	30.5	84	26.69	292	32.4	585	89.6
	СЭМТ-ийн дүн	2,422	300.6	802	185.1	1,663	256.6	4,887	742.3
1	Боржигон Мандал ӨЭМТ	71	6.5	12	0.6	2	3.1	85	10.2
2	Өлзийт мандал ӨЭМТ	236	15.2	92	1.2	96	5.3	424	21.7
	ӨЭМТ-ийн дүн	307	21.75	104	1.71	98	8.38	509	31.8
	Нийт дүн	2,729	322.3	906	186.9	1,761	264.98	5,396	774.2
	Лавлагаа шатлалын ЭМТ-ын төлбөртэй үйлчилгээний санхүүжилт								
1	Нэгдсэн эмнэлэг	1,003	519.8	1,049	557.6	1,754	608.5	3,806	1,686.0
2	Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг	65	31.8	226.00	61.3	72.00	56.4	363	149.5
	ӨЭМТ-ийн дүн	1,068	551.6	1,275	618.9	1,826	664.9	4,169	1,835.4
	Нийт дүн	3,797	873.9	2,181	805.8	3,587	929.9	9,565	2,609.6

Хавсралт № 11 Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн хасагдлын нийтлэг шалтгаан

№	Тусламж үйлчилгээний төрөл	Хасагдлын шалтгаан
Эмчийн хасагдал		
1.	Өдрийн эмчилгээ болон хэвтүүлэн эмчлэх эмийн эмчилгээ:	Эмнэл зүйн удирдамж мөрдөөгүй, анхан шатны маягт ирүүлээгүй, тусламж үйлчилгээг давхардуулж нэхэмжилдэг, / оношилгоо шинжилгээг эмийн эмчилгээ болон өдрийн эмчилгээтэй давхар нэхэмжилдэг, (өдрийн эмчилгээ болон эмийн эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд оношилгоо шинжилгээний зардал багтсан байдаг.) эмнэлэгт хэвтсэн огноо,цаг, минутыг тэмдэглээгүй, өвчний түүх болон тухайн өвчтөнд илэрч байгаа шинж тэмдгийг дутуу илрүүлэх, онош тогтооход шаардлагатай нарийн оношилгоо шинжилгээ болон холбогдох оношилгоо, шинжилгээг хийгээгүй, эмнэлэгт хэвтсэнээс хойш хийгдсэн оношилгоо, шинжилгээг тухайн хэвтэж байгаа эмнэлэгтээ хийлгээгүй (зарим тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлэгт хамаарахгүй), бодит үзлэгийг дутуу хийдэг, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 тоот тушаалын хавсралтад заагдсан үзлэгийг бүрэн хийдэггүй, өвчний түүхийн клиникийн оношийн үндэслэлийг 3-5 хоногт хугацаанд бичээгүй, ялган оношлох эмгэг ба хам шинжүүдийг тодорхойлоогүй, хэвтсэнээс хойш 2-4 цагийн дотор эмчилгээ хийх тэмдэглэл хөтлөөгүй, асаргаа сувилгааны тэмдэглэл бүрэн хөтлөөгүй, өвдөлт хянах хуудас болон сувилагч эхийг биеийн байдлыг үнэлэх хуудас, сувилахуйн тэмдэглэл, эхийн амин үзүүлэлтийг хянах хуудсыг хөтлөөгүй, төрөхөөс гарах үеийн эпикризийг дэлгэрэнгүй бичээгүй, үйлчлүүлэгчид дэлгэрэнгүй зөвлөгөө өгч өрх, сум, тосгоны болон мэргэжлийн эмчийн хяналтад гаргасан тухай тэмдэглэл бичээгүй, эмчлэгч эмч өдөр бүр үзлэгийн тэмдэглэл хөтлөөгүй, эмчилгээний хоолны заалтыг өдөр бүр тэмдэглээгүй, анхан шатны маягтыг хоосон хөтлөөгүй илгээх;
2.	Яаралтай тусламж үйлчилгээ:	Багажийн оношилгоо- Тухайн эрүүл мэндийн байгууллагад багажийн оношилгоо хийгээгүй; Лабораторийн шинжилгээ- Тухайн эрүүл мэндийн байгууллагад биохимийн шинжилгээ хийгээгүй, тухайн эрүүл мэндийн байгууллагад цусны ерөнхий шинжилгээ хийгээгүй, тухайн эрүүл мэндийн байгууллагад шээсний ерөнхий шинжилгээ хийгээгүй; Сувилагчийн үзлэг, хяналт - Эмчийн гаргасан заалтын дагуу үйлчлүүлэгчийг тогтмол хянаж, тэмдэглэлийг бүрэн хийгээгүй, яаралтай тусламжийн тасагт ирэх үеийн болон шийдвэрлэх үеийн амин үзүүлэлтийг үзэж, тэмдэглээгүй, яаралтай тусламжийн эрэмбийг тодорхойлж тэмдэглээгүй; Эмчийн үзлэг, зөвлөгөө- Бодит үзлэгийг бүрэн хийж, тэмдэглээгүй, үйлчлүүлэгчийн эмнэл зүйн нөхцөл байдалд тохирсон эмчилгээ, зөвлөмжийг өгч, тэмдэглээгүй, эмчилгээний маягт хавсаргаагүй;
3.	Түргэн тусламжийн үйлчилгээ	Дуудлагын км бичээгүй, түргэн тусламжийн дуудлагын дүгнэлтийг бичээгүй, түргэн тусламжийн эмчийн нэр бичигдээгүй, гарын үсэг зураагүй, дуудлага өгсөн байршилд очих хүртэлх хугацаанд авах арга хэмжээний талаар зөвлөгөө өгсөн эсэхээ тэмдэглээгүй, дуудлага хүлээн авсан эмнэлгийн

	мэргэжилтний нэрийг бичээгүй, дуудлага хүлээн авсан огноо, цаг минутыг тэмдэглээгүй, даатгуулагчийг эмнэлэг рүү тээвэрлэж байгаа үед тээвэрлэлтийн явцад хүргэж буй эмнэлгийн яаралтай тусламжийн хэсгийн эмчтэй холбогдож мэдээлсэн тухай тэмдэглэл байхгүй, тээвэрлэх явцад эмнэлгийн тусламж, үйлчилгээ тодорхой түвшинд үзүүлсэн тухай тэмдэглэл байхгүй, хүлээн авсан эмнэлгийн яаралтай тусламжийн эмчийн нэр, гарын үсэг зурагдаагүй, эмнэлэгт тээвэрлэн хүргэсэн огноо, цаг минутыг тэмдэглээгүй, дуудлагыг эрэмбэлээгүй;
Цахим хасагдал	
Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэнд үзүүлсэн тусламж үйлчилгээг нэхэмжилсэн Оношийн хамаарлын бүлгийн нэр, ангиллыг зөрүүтэй илэрхийлсэн Амбулатори, яаралтай тусламж, хэвтэн эмчлүүлсэн иргэний эрүүл мэндийн тусламж үйлчилгээг давхардуулсан	

Хавсралт № 12 Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг өр авлагын судалгаа –

2021-2025 он /сая.төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Өр төлбөр					Нийт	Авлага					Нийт
		2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он		2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	
1	Адаацаг	-	-	0.0	0.8	5.8	6.6	-	-	11.3	200.3	63.7	275.2
2	Баянжаргалан	0.5	26.1	2.4	3.5	40.5	73.0	-	0.1	7.9	35.6	5.5	49.0
3	Гурвансайхан	-	-	7.7	-	0.4	8.1	69.2	2.8	6.9	86.4	32.0	197.4
4	Дэлгэрхангай	-	-	-	-	-	-	94.5	-	5.9	149.0	6.3	255.6
5	Дэлгэрцогт	-	0.2	2.2	16.0	-	18.3	18.5	9.5	28.1	78.0	27.6	161.7
6	Дэрэн	27.3	-	16.1	29.0	9.5	82.0	102.7	-	10.7	64.8	7.3	185.5
7	Луус сум	48.1	-	31.4	22.0	49.1	150.6	236.9	-	8.5	46.2	14.8	306.5
8	Өндөршил	10.7	-	0.3	30.0	3.7	44.6	110.3	0.7	10.0	62.4	5.4	188.8
9	Сайнцагаан	-	-	-	-	-	-	83.1	-	12.4	151.5	42.5	289.4
10	Сайхан-Овоо	-	-	10.5	27.5	3.9	41.9	0.4	0.3	3.0	98.2	15.9	117.8
11	Хулд	-	-	1.3	25.8	14.4	41.5	-	8.0	11.9	122.9	27.2	170.1
12	Цагаандэлгэр	-	-	20.3	65.8	5.1	91.2	-	0.2	30.2	39.0	25.9	95.4
13	Өлзийт	61.1	-	-	2.2	1.4	64.7	-	-	5.5	182.3	7.0	194.8
14	Говь-Угтаал	21.5	40.2	60.3	42.9	13.9	178.8	92.0	-	0.5	72.9	45.2	210.6
15	Эрдэнэдалай	-	4.0	7.4	3.9	20.6	35.9	-	-	24.5	272.2	22.6	319.3
16	Боржигон мандал	6.8	8.3	17.1	18.7	-	51.0	83.1	0.0	9.3	95.4	-	187.8
17	Өлзийт мандал	5.3	7.9	0.5	-	-	13.7	182.4	-	12.7	33.7	28.9	257.6
18	Нэгдсэн эмнэлэг	589.0	334.1	1,755.1	1,644.5	2,473.0	6,795.7	762.8	26.9	175.6	6.1	557.5	1,529.0
19	УАУНЭ	3.3	-	-	-	5.7	9.0	18.4	-	22.2	155.4	26.8	222.7
Нийт		773.6	420.8	1,932.6	1,932.7	2,646.9	7,706.6	1,854.2	48.6	397.1	1,952.2	962.0	5,214.0

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn 